



И. САНЬЦАРЬ

Уутхан түүний нөхдөл  
ТОХИОЛДСОН

АДАЛ  
ЯЗДАЛ





И.Саньцар

АРЬ


Уутхан

ТҮҮНИЙ НӨХДӨЛ



ТОХИОЛДСОН

адал эвдал



Улаанбаатар хот  
2007 он

И.Саньцар

## УУТХАН ТҮҮНИЙ НӨХДӨД ТОХИОЛДСОН АДАЛ ЯВДАЛ

Сургуулийн бага, дунд насныханд зориулав.

Зураг чимэглэлийг И.Саньцар, С.Төгс-Оюун  
Хянан тохиолдуулагч О.Мөнхтуяа  
Хянасан Ж.Гэрэлмаа  
Хэвлэлийн эх бэлтгэсэн Р.Баярмагнай



Хэвлэн нийтлэлийг Интерпресс ХХК

2007 он

## БУВАРДАЙ ДЭГДҮҮЛЭЙ ХОЕР

Хүүхдүүд та нар анзаардаг уу? Гудамж талбайн хаа нэгтээ ч юм уу, цардмал замын хажууд, эсвэл хашаа байшингийн булан тохойд чухам хаашаа одсон нь үл мэдэгдэм харанхуй нүх хонгилууд тааралддаг биз дээ? Зарим нь



замын хажуугийн зүлэг ногоонд дарагдаж үнэхээрийн нууцлаг байдалтай ч үзэгддэг.

Энэ хонгил тус тусдаа эзэнтэй, хачин сонин түүхтэй ч байж магад. Доороо хүнсний дэлгүүртэй өндөр ягаан байшингийн залгаа, тоосгон хашааны доор нууцгайхан байрласан нэгэн хонгил байдаг. Энд баатарлаг үйлс бүтээх дуртай жижигхэн хөөрхөн, аятайхан амьтан амьдран суудаг гэнэ. Түүний нэрийг Бувардай гэнэ.

Бувардай өнөөдөр хүн амьтны яаран алхлах хөлийн чимээнээр сэрэв. Түүнд бараг хийх ажил байгаагүй ч ямар нэг чухал үйлс заавал бүтээе гэж бодоод хурдлан босч цэцэрлэгт хашаанд оржээ. Тэнд Бувардай, хүүхдийн тоглож байгаад орхисон элсэн цамхаг, байшингаар тоглох маш их дуртай. Яагаад гэвэл хүүхдүүд яг жинхэнэ юм шиг орд харш барьсан байдаг юм. Хашаан дотор байх хорхой шавж дөнгөж сая босоцгоосон байгаа бололтой өтгөн ургасан өвсний наагуур цаагуур унд цайгаа уухаар хөлхөлдөнө. Тэднийг сонирхон ажигласаар явтал бут сөөг сийрч, хүүхдүүдийн тоглодог элсэн талбай харагдав. Элсний хашлага дээр Дэгдүүлэй бор шувуу сууж байна. Тэр Бувардайг харсан боловч их завгүй янзтай, хэн нэгнийх нь орхисон талхны захыг тоншиж байв.

- Дэгдүүлэй, сайн байна уу? Би Бувардай байна гэхэд тэрбээр дуугарсангүй, далавчаараа далласан болчлоод талхныхаа захыг

улайран тонших ажээ. Түүнийг тэгж их шаламгайлан байхад талхны зах, элсэн дээр гаргаад хаячихсан загас шиг нааш цааш үсчин тонгочно. Бувардай тэр талхны захыг “Үнэхээр алтан загас болон хувирчихгүй байгаа” хэмээн горьдож, баахан ажиглаж зогссоноо Дэгдүүлэйг араас нь чангааж,

- Дэгдүүлэй! Чи намайг яагаад тоохгүй байна вэ? гэж гомдонгуй хэлэв. Дэгдүүлэй найз уруугаа харж,

- Бувардай, чи битгий надад саад болооч! Би чамайг харангуутаа мэндэлж далавчаа дохисон шүү дээ. Би өнөөдөр нэг шинэ юм сэдэж олсон юм. Энэ талхны хальсыг цоо тоншиж болно гэж саналаа. Гэтэл чи надад садаа болоод, элдэв юм шалаад байх юм гэж зэмлэв. Бувардай өөрийгөө зөвтгөж,

- Уучлаарай, би анзаарсангүй. Би чамайг далавчаа зүгээр дэвсэн юм байх гэж бодсон юм. Далавчаа дэвэхээр мэндэлдэг юм бол нисч явахдаа хэнтэй мэндэлдэг юм бэ? гэхэд Дэгдүүлэй тэр дороо гайхаж, “Би нисч явахдаа хэнтэй мэндэлдэг юм бол” гэж бодсоноо,

- Нисч явахдаа юу? Энэ дэлхийн бүх амьтантай мэндэлдэг юм. Би чамайг аль эрт дээгүүр чинь нисч өнгөрөхдөө мэндэлсэн юм уу? Яаж мэдэх вэ гэж уцаарлав. Бувардай маргасангүй, түүний одоо хэр хугалж амжаагүй байгаа талхны захыг шинжлэн үзээд чимээгүй болов. Тэгээд ийн хэлэв.

- Чи үнэхээр сонин зүйл сэдэж олжээ. Харин би баатарлаг үйлс бүтээхээр бодож олоод явж байна гэж гайхуулав.

- Пөөх, чи бас шинэ юм санаж олсон уу? гэж Дэгдүүлэй сэтгэл ханамжтай дуу алдаад, баатарлаг үйлс гэдэг чинь юу юм бэ? гэж лавлав.

- Баатарлаг үйлс үү? гэж бодолхийлснээ энэ бол сайн үйлс гэсэн үг гэж өгүүлэв. Дэгдүүлэй бодлогоширсоор,

- Сайн үйлс гэнэ ээ? хэмээн амандаа давтан нэг л сайн ойлгохгүй тээнэгэлзэн байхад, Бувардай цааш нь,

- Энэ үү дээ, өөрөө хэчнээн зовж зүдэрч байвч бусдыг баярлуулах гэсэн үг.

- Чиний бодож олсон зүйл чинь заавал зовж зүдэрч байх ёстой юм уу? Чи одоо баатарлаг үйлс бүтээхийн тулд зовж зүдрээд зогсож байгаа нь энэ үү? хэмээн итгэж ядсан байртай асуухад, Бувардай ундууцаж,

- Үгүй үгүй, би чамд ойлгуулахын тулд тэгж хэлсэн юм. За байз,

чамд яаж тайлбарладаг юм билээ? Хамгийн ерөнхийгөөр хэлбэл бусдад тус хүргэх гэсэн үг. Харин тэр тусыг хүргүүлэхгүй гэж саад тотгор тохиолдож байх ёстой бөгөөд түүнийг даван туулж гэмээ нь баатарлаг үйлс бүтээх нь тэр. Одоо чи ойлгов уу? гэж ямар ч болов тайлбарлаж чадсандаа баярлаж асуувал,

- Өө энэ юм уу. Тэгвэл манай хашаанд л лав тийм юм байхгүй. Тус хүргэх гээд очиж байхад хэн тус хүргүүлэхгүй гэж цааргалж, саад тотгор учруулж байх вэ дээ! Хэнээс ч гэсэн тус хүргэх үү чамд гэж асуувал, цөмөөрөө л тэг тэг гэж дуртай зөвшөөрнө. Тэгэхээр чиний бодож олсон баатарлаг үйлс бүтэхгүй. Би хувьдаа больё. Би талхныхаа захыг тонших минь гээд Дэгдүүлэй цааш эргэв. Бувардайн урам хугарч,

- Нээрээ тийм гэжүү? хэмээн гунигтай нь аргагүй шивээнэлээ. Одоо тэгээд юу хийх болж байна аа гээд бодлогошрон суув. Дэгдүүлэйг талхны булантай ноцолдож байхыг ажиглан сууж байснаа Бувардай тэссэнгүй,

- Би чамд тусалъя. Чи ганцаараа дийлэхгүй юм шиг байна гэж хэлбэл Дэгдүүлэй зөвшөөрсөнгүй.

- Хэрэггүй, би өөрөө. Би өөрөө бодож олсон юм чинь гэснээ гэнэт Бувардай өөд гайхан ширтэж одоо би чамтай зөрсөн юм чинь чи миний буланг хуга татахаар надтай ноцолдвол баатарлаг үйлс болох уу? гээд болгоомжлон ухрав.

- Яалаа гэж тэр вэ? Тус хүргэж гавьяа байгуулах хэрэгтэй шүү дээ. Чамд би туслах гээд чамтай ноцолдохоор ямар гавьяа байх вэ гэв.

- Гавьяа байгуулж бусдад тус хүргэх гэнэ ээ? Тэгвэл ч манай хашаанд бий шүү. Би сая бодож оллоо. Хашааны мухарт ургадаг тэмээн шээгний бутыг дүрсгүй хүүхдүүд гишгэж, хуга дарсан байна билээ. Түүнийг босгож дахин гишгүүлэхээс хамгаалж тус хүргэе гэхэд Бувардай уухайн тас хүлээн авч,

- Тийм үү? одоохон тийшээ явъя. Сайн үйлсийн төлөө урагшаа, найз минь гэж баяртай уриалав. Дэгдүүлэй газар хэвтэх талхны хатсан захыг тал талаас нь ажиглан харж, хэсэг бодолхийлснээ,

- За тэгье, чи түрүүлээд очиж бай. Би энэ захыг хуга тоншчихоод хойноос чинь очъё гэжээ. Бувардай хашааны мухарт буй бутны зүг хөдлөв. Нурж унасан элсэн цамхгуудыг сонирхон, элсний банзан хашлагыг даган явахад Дэгдүүлэйн тоншиж байгаа дуу сонсогдсоор



байлаа. Дээр цэв цэнхэр тэнгэр харагдана. Баруунтаа нь гоёмсог ягаан байшин сүндэрлэнэ. Бувардай ногоон зүлгэн дундуур гаталж зорьсон бутандаа хүрч ирэв. Хөөрхий бутны нэг мөчир нь булгарч унаад газар хэвтэнэ. Ногоон навч нь хорчийн хатаж эхэлжээ. Бувардай унасан мөчрийг мөрлөн өргөж, эвээр нь нийлүүлэх гэж оролдов. Ганцаараа бүтээх ажил биш ажээ. Тэгээд гайхаад зогсож байтал Дэгдүүлэй нисч ирэв. Тэр газар буунгуутаа,

- За эхлэх үү? гээд дороо тогтож ядан дэвхцэж, ийш тийш хялбалзан хараад Бувардайд туслахаар явав. Тэр хоёр оролдож оролдож, арай гэж мөчрөө босгоод жижигхэн модоор түшүүлж

шидмэсээр боов. Босгосон мөчрөө амь орж байгаа эсэхийг ажиглан, амрахаар сууцгаав. Бувардай санаа амарсан байртай шүүрс алдаж,


- Сайн үйлс гэдэг чинь энэ дээ. Сайхан байна уу? гэж асуув. Дэгдүүлэй зөвшөөрч толгой дохиод,

- Сайхан байна гэж хариулав. Тэгснээ баатарлаг үйлс нь хаана байгаа юм бэ? гэж асуулаа.

- Энэ сайн үйлс бид хоёрын зориг сэтгэлтэй нийлж баатарлаг үйлс болж байгаа нь тэр дээ гэв. Тэр хоёр хоёулаа маш их баяртай, сэтгэл хангалуун байна. Энэ үед Түнтүүлэй гэдэг бүдүүн задууль бялзуухай тэдний дэргэдүүр нисч явснаа бушуухан агаарт нэг эргээд Дэгдүүлэйн дэргэд тоос шороо манаруулан пид хийтэл буув. Түнтүүлэйн босгосон шороо хамар амаар орж, хоолой загатнуулахад тэд найтаалгав.

- Чи минь хаанаас нисч ирэв хэмээн Бувардай найтаалгасаар асуухад, Түнтүүлэй цэцэрхэж,

- Хаанаас нисч байгаа нь хамаагүй. Хаашаа нисч яваа нь чухал гэв. Дэгдүүлэй Бувардайн тавьсан асуултыг дор нь залруулж,



- За тэгвэл чи хаашаа нисч явна? гэв. Түнтүүлэй хэнэг ч үгүй түүнийг нэгэнтээ ширвээд,

- Та хоёр уруу нисч явна гэж хариулав. Дэгдүүлэй ингэж гэнэдэж амаа таглуулсандаа самгардаж хий л нүдээ анивчиж байв. Ингээд асуух, ярих юмаа олж ядан эвгүйцэж байтал Түнтүүлэй тэдний босгосон мөчрийг үзээд,

- Та хоёр юу хийж байгаа юм бэ? гэж асуулаа.

- Бид хоёр баатарлаг үйлс бүтээсэн юм гэж Дэгдүүлэй бахархалтай нь аргагүй өчив. Гэтэл нөгөөдөх нь:

- Энэ чинь миний мөчир байна шүү дээ хэмээн улайм цайм хэлсэнд Бувардай маш их сандарч,

- Худал ярь. Хугарсан байхыг нь Дэгдүүлэй анх харсан юм гэж итгэл муутайхан эсэргүүцэв.

- Би Дэгдүүлэйгээс өмнө нисч яваад энэ мөчрийг үзэж "Энэ минийх" гэж хэлээд өнгөрсөн юм. Иймээс энэ миний мөчир байх ёстой. Би баатарлаг үйлс бүтээх гэж байтал та хоёр миний баатарлаг үйлсийг булааж авсан байна. Би мөчрөө буцааж авна гэж Түнтүүлэй зөрөв. Бувардай түүнд,

- Одоо нэгэнт баатарлаг үйлс бүтсэн учир хэний ч мөчир байсан өнгөрчээ гэхэд Түнтүүлэйн өөртөө итгэсэн бардам хэнэггүй байдал ор тас алга болжээ. Хайран сайхан баатарлаг үйлс Бувардай Дэгдүүлэй хоёрынх болсонд харамсаж хэлэх үгээ олж ядан, нааш цааш холхиж, өөр сайн үйлс бутан дотор хэвтэж байж магадгүй хэмээн дээгүүр доогуур шагайв. Түүний тэвдэж, гүйлгэнэх нүдийг хараад Бувардай Дэгдүүлэй хоёр тэсэлгүй инээд алдав. Түнтүүлэй найз хоёр луу гоморхон хараад,

- Та хоёр нийлж бусдыг дандаа шоолох юм гэж бачимдан үглэснээ "Наад муу хатсан мөчрөөс чинь энэ том мөчир хамаагүй дээр" гэж хэлээд дэргэд ургах тэрэлжийн бутыг уурандаа шүүрэн авч далавчаа хүчлэн дэвсэн ч нисч чадалгүй үлджээ.

- Түнтүүлэй болиоч. Наад бутая тасалчихна гэж Дэгдүүлэй болгоомжлон хашгирахад,

- Бут тасалбал муу үйлс болно. Тасдахгүй бол сайн үйлс болно. Гурвуулаа сайн үйлсээ хувааж авъя гэж аргадав. Тэгж тэгж, Түнтүүлэй буцаж бууж ирэв. Тэгээд,

- Чи бут тасалсангүй. Энэ чинь сайн үйлс юм. Одоо сэтгэлд чинь нийцэж байна уу? гэхэд Түнтүүлэй уурласан хэвээр,

- Мэдэхгүй гэж урвайж байснаа,
- Нээрээ нийцэж ч байгаа юм уу? гэж эргэлзсэн шинжтэй дуугарав.
- Тэр шүү! Тэгвэл чи сайн үйлсээ авчээ гэж Дэгдүүлэй баясгалантайгаар өгүүлэв.

## **БУВАРДАЙ ОНГОЦ ХИЙЖ ДЭГДҮҮЛЭЙТЭЙ ХАМТ НИССЭН БА УУТХАНЫГ АВАРСАН НЬ**

Модны навч ч хөдөлгөх салхигүй бүгчим халуун дүүгж байна. Хаяагаа сөхөөд л гэртээ хэвтэж баймаар өдөр боловч Бувардай баатарлаг үйлс яаж бүтээдэг юм билээ гэж бодож суув. Ашгүй Дэгдүүлэй ирлээ. Тэрбээр шууд л босгон дээрээс хашхирч,

- Бувардай, явъя! Сая би гоё төмөр торонд суудаг бяцхан амьтан үзлээ гэж яаруулав. Бувардай гайхаж,

- Хаана тэр вэ? гэж асуув.

- Цонхон дээр. Хоёр давхрын цонхон дээр гэв.

Би яаж хоёр давхарт гарах билээ? гэхэд Дэгдүүлэй түүнийг сая анхааралтай ажигласнаа,

- Нээрээ чи нисч чаддаггүй билүү? Би тэр тухай огт санасангүй. За яахав болихоос доо. Уул нь би чамд гоё юм харуулъя гэсэн юм гээд урамгүйхэн эргэхэд Бувардай гэнэт нэг зүйл сэдсэн бололтой,

- Дэгдүүлэй, хүлээгээрэй. Би нэг арга оллоо гээд агуулах уруугаа ороод дэвтрийн цаас, утасны тасархай, нарийн зэс утас олж ирэв. Дэгдүүлэй гайхан алмайрч,


- Чи яах гэж байгаа юм бэ? хэмээн анивчин асуув.

Түүнийг хараад Бувардай:

- Би чамтай хамт ниснэ гэж хөгжилтэй хэлэв. Дэгдүүлэй улам гайхаж,

- Яаж нисэх юм бэ? Би чамайг даахгүй шүү дээ гэвэл,

- Үгүй би чам дээр суухгүй. Цаасан онгоц хийж ниснэ. Харин чи надад жаахан туслаарай гэж тайвшруулахыг оролдов. Дэгдүүлэй ч жаахан тайвширч,



- Уг нь нисэх амархан шүү дээ. Далавчаа хэд дэвээд л хөөрчихнө гэх мөртлөө, харин наад цаас болон элдэв хог чинь яаж нисдэг бол доо! гэж нэг л итгэж өгөхгүй бодолхийлэн байлаа.

Тэр хоёр зүлгэн дээр цаасаа дэлгэж тавиад хэмжиж хэмжиж нугалж гарав. Ам дөрвөлжин цаасыг хошуулдан нугалж илүү гарсан үзүүрээр нь тэвхдээд эсрэг талаас нь хоёр хажуугаар нь нугалж, далавч гаргав.

Ингээд яах ийхийн зуургүй цаасан онгоц бүтээв. Түүнийхээ доороос хөнгөн цагаан утсаар суудал хийж дүүжилнэ. Онгоцныхоо хошуунаас утсаар аргамжиж бариул гаргаад чирэхэд тохиромжтой болгов. Салхи сэр сэр үлээхэд цаасан онгоцны далавч далбилзан хөдөлж нисэхийг завдан, чичигнэх үед Дэгдүүлэйн дурамжхан байсан сэтгэл сэргэж,


- Нээрээ энэ онгоц өөрөө нисэх гээд байна шүү гэж баярлан хашгирна. Бувардай цаасан онгоцоо толгой дээрээ өргөн төмөр торноос барьж, элсний зүг явав. Дэгдүүлэй түүний хойноос ухасхийж газар чирэгдэх утасны үзүүрээс шүүрэн авч Бувардайг гүйцэх санаатай яаран зүтгэж,

- Хэн түрүүлж нисэх вэ? гэж лавлав. Элснээс холгүй ногоорох нуга дээр тэр хоёр хүрч ирэв. Бувардай онгоцоо зүлгэн дээр тавьж,

- Тэгэхээр чи утсаа чирээд түрүүлж ниснэ. Би чиний хойноос онгоцоо үүрээд гүйнэ. Тэгээд... гэтэл Дэгдүүлэй цочисхийн,

- Тэгээд яах гэж, гүйгээд л байх юм уу? Хэзээ нисэх юм бэ? гэж түүний яриаг тэсгэлгүй таслахад, Бувардай толгой сэгсэрч,


- Хэлэх гэж л байна шүү дээ. Жаахан тэвчээртэй байгаач! Жаахан гүйж байгаад л нисчихнэ гэхэд Дэгдүүлэй бас л ойлгоогүй бололтой,



- Гүйх ямар хэрэгтэй юм бэ? Би шууд л нисчихдэг шүү дээ гэж үглэсээр түүний хойноос дагав. Ойр хавийн хорхой шавж, ногоон зүлгэн дээр дэврэх хөөрхөн онгоцыг сонирхон харцгааж байлаа. Бувардай тэднийг нэгэнтээ ширвэн хараад, тоомжиргүйхэн даллаж,

- За, Дэгдүүлэй нисээрэй! гэж хэлэхэд Дэгдүүлэй далавчаа дэлгэн баахан гүйв. Түүний араас Бувардай цаасан онгоцоо толгой дээрээ өргөн аахилан гүйж, зүлэгний зах дээр ирэх үед онгоц хөөрч газраас тасрав. Дэгдүүлэй нисч өндөр авахад, тэртээ доор таван салаа навч, багваахай цэцэг, цээнэ, хонхон цэцэг, эрээлжлэн харагдана. Бувардайн чихэнд салхи исгэрэн хурдан явснаас нүдний нулимс асгарч доорх элс нуга бүдгэрэн усан будгаар будсан мэт хоорондоо нийлэн солонгорох ажээ. Доошоо харвал хажуугийн хашаанд талын цагаан мөөг шиг бөмбийсөн гэрүүд үзэгдэх нь нэн гайхалтай. Байшингийн дээврийн цаана олон сайхан барилга, цэнхэрлэх манан дунд дүнхийж, бүүр цаагуур нь модтой их уулс хөхрөн харагдаж байв. Бувардай Дэгдүүлэй хоёр болгоомжтой нисч нөгөө сонин амьтан байсан цонхыг зүглэв. Олон цонх хажуугаар нь маш хурдан жирэлзэн өнгөрч байсан боловч айлын цонхны цаад талыг шохоорхон харж амжиж байв.

Нэг цонхон дээр устай саванд байгаа алтан загасыг гоочлох санаатай суусан эрээн муур Бувардайг хараад гайхсандаа амаа ангайлгаж, цонхон дээр яах гэж гарснаа таг мартсан бололтой гөлөрсөөр хоцров. Ингээд нисч явтал цонхны тавцан дээр гоёмсог төмөр тор харагдав. Намрын дулаахан орой цонхыг нь цэлийтэл



нээсэн өрөөнд хэн ч харагдсангүй. Тэр торон дотор хулганатай адил хөөрхөн жижигхэн амьтан сууж байна. Дэгдүүлэй, Бувардайг чирэн эргэлдэн нисч торонд аль болохоор ойртохыг хичээнэ. Дэгдүүлэйн далавчны чимээгээр нөгөө амьтан өндийж тэр хоёрыг харав. Тэр гурав бие биесээ ширтэлцэн энэ тэр зүйлийг шохоорхон хэсэгхэн болов.

Дэгдүүлэй, Бувардай хоёр буухаар шийдлээ. Дэгдүүлэй өндрөө тааруулж, тор байгаа цонхыг чиглэн шумбан оров. Бувардай ч гэсэн хэрэндээ онгоцоо залах гэж займчин хөдөлгөсөөр цонхоор сурхийн орж номын шүүгээний дэргэдэх оронд ойртож ирмэгцээ гэдийн, хурдаа сааруулж зөөлөн дэвсгэр дээр буув. Дэгдүүдэй их сандрав. Бувардай будилж будилж онгоцон доороосоо арай ядан гарч ирлээ. Торон дотор байгаа амьтан тэр хоёрын шуугихыг сонирхон ажиглаж, Бувардай Дэгдүүлэй хоёрыг тавцан дээр гарч ирэхэд сая сэтгэл нь амрав. Бувардай амьсгаагаа дарах сэхээ авалгүй торны зүг яарч,

- Бид хоёр таны торыг үзэх гэж тэр харагдаж байгаа байшингийн цаанаас нисч ирлээ хэмээн үдшийн бүрийд сүүмийн харагдах байшингийн зүг заав.

- Би ч бас гэж Дэгдүүлэй хажуугаас нь хошуу нэмэрлэх боловч тавцангийн ирмэг дээр цаасан онгоцоо гаргах гэж зүтгүүлээд, тэдэнтэй ярилцах заваар муухан байлаа.

- Таны тор ямар гоё юм бэ? Бид ийм торонд сууж үзээгүй л дээ гэж Бувардай их л эелдгээр яриа дэлгэв. Дэгдүүлэй ганцаараа зүтгүүлж цаасан онгоцоо тавцан дээр гаргах гэж ядарсандаа болоод нэлээд дурамжхан байлаа.

- Шал дэмий тор байна. Салхи жавар ч хаахгүй, сарзайсан төмрөн дотор яаж тэсч суудаг юм бэ? За явъя гэж яаруулав.

- Эрхэм нисгэгчдийн нэр алдрыг ч мэдэж амжилгүй салах нь шив дээ гэж нөгөө амьтан өгүүлэхэд Дэгдүүлэй ярьсан чигээрээ,

- Чамайг хэн гэдэг юм бэ? Намайг Дэгдүүлэй гэдэг юм. Би дэлхийн хамгийн анхны туршин нисгэгч. Одоо бол би энэ Бувардайг туршиж байгаа юм гэж яриw. Бувардай өөрийг нь туршиж байгаа гэдгийг сонсоод дургүйцэж,

- Дэгдүүлэй битгий худал ярь. Чи миний юуг туршиж байгаа юм бэ? гэж асуув. Гэтэл цаадах нь Бувардай юуг туршиж байгаагаа сайн хэлж мэдэхгүй байсан тул арга буюу буулт хийж,

- За за худлаа. Бувардай намайг туршиж байгаа юм гэж залруулав. Бувардай тэгэхэд сэтгэл ханасангүй,

- Үгүй, Дэгдүүдэйг ч би туршаагүй юм. Харин түүний туслалцаатайгаар цаасан онгоц туршин нисч байна гээд,

- Харин чамайг хэн гэдэг юм бэ? Чи онгоцоор нисч үзсэн үү? гэж асуулаа.

- Намайг уу? Би нэргүй. Намайг Австрали тивээс авчирснаас хойш нэр өгөөгүй байгаа юм. Хүмүүс намайг уутат хулганын төрөлд багтаадаг юм. Би нисч үзэлгүй яахав гэлээ. Дэгдүүлэй баярлаж,

- Би тэгвэл чамд нэр өгье. Би хэнд ч нэр өгч үзээгүй. Би чамд нэр өгье. Би чамайг Уутхан гэе хэмээн дуу алдав. Бувардай ч түүнийг дэмжиж нээрээ тийм. Чамд Уутхан гэж нэр өгье. Чи бидэнтэй нисэхгүй юу? Торноосоо гараад ир гэв. Уутхан тэр дороо уйтгарлаж,

- Хэрвээ би энэ торноос гарч чаддаг байсан бол өдийд юу хийж энд сууж байх билээ дээ. Би эндээс гарч чадахгүй гэхэд Дэгдүүлэй гоморхож,

- Яагаад гарч чадахгүй байх билээ? Би чамд нэр өгөөд байхад бидэнтэй танилцах дургүй байгаа юм уу? Эсвэл чи нисч үзсэн гэж худлаа ярьсан юм уу? Бидэнтэй нисэхээс айгаад байна уу гэхэд

- Яалаа гэж би та хоёртой танилцахад дургүйцэх вэ? Намайг зугтаж магадгүй гэж энд цоожилсон юм. Тэр түгжээг яаж онгойлгох вэ? гэж хаалгыг тэвхэдсэн аварга том төмөр дэгээг заав. Бувардай сая сэхээ авч,

- Уутхан чи нээрээ торноосоо гарч чадахгүй байгаа юм уу? Дэгдүүлэй, тэгвэл хоёулаа түүнийг аварья. Энэ чинь бас баатарлаг сайн үйлс шүү дээ гэж ярилцав. Тэр хоёр хаалганы дэгээг үзэв.

- Өө, энэ чинь юу байсан юм бэ? Бувардайг чирээд нисч дийлсэн юм чинь үүний дэгээг салгаж чадах байлгүй гээд нисч дэгээнээс шүүрэн зүтгүүлсэн боловч хөдөлгөж дийлсэнгүй. Гагцхүү сэрвэлзэн дэвэх далавчнаас хүчтэй салхи үлээж байв.

- Та нар харж бай. Би одоохон онгойлгоно гэж сүржигнэх боловч тэр дэгээ сэнжнээсээ мултрах шинжгүй. Дэгдүүлэйг ингэж онгирч байх завсар Бувардай дэгээг сайтар ажиглан үзээд,

- Дэгдүүлэй, наашаа бугаад ир. Май, энэ утасны үзүүрийг хаалганы дээд талын хөндлөн төмрийг давуулаад дэгээнээс уяад орхи гэж зааж өгөхөд Дэгдүүлэй цонхон дээр хэвтэх онгоцны уяаны үзүүрийг Бувардайн хэлснээр дэгээнд арай ядан уяв. Тэднийг ингэж мунгинасаар байтал харанхуй боллоо. Дэгдүүлэй утасны үзүүрийг сайн уясан эсэхийг шалгаж үзээд "бэлэн боллоо" гэж хашгирав. Бувардай унжсан утаснаас барьж,

- Дэгдүүлэй бид хоёр утаснаас чангааж дэгээг өргөхөөр чи торны хаалгыг түлхэж онгойлгоорой гэж Уутханд зааж өгөв. Ингээд тэр хоёр утаснаас хар тэнхээгээрээ татав. Торон хаалганы түгжээ мултарлаа. Уутхан Бувардайн дохиогоор хаалгыг түлхэхэд төмөр хаалга хяхтнан дэлгэгдлээ. Бувардай Уутханыг торноос гарахад туслах зуур,

- Дэгдүүлэй, уяагаа тайлаарай! Одоо нисэцгээе гэж хэлж дуусаагүй байтал өрөөний хаалга онгойж сагсгар хавны хошуу цухуйлаа. Дэгдүүлэй дэгээний хөндлөн төмөрт уясан утсаа тайлахаар оролдож байв. Сагсгар хав зүтгэсээр байгаад өрөөнд ороод ирэв. Түүний нүд шөнтгөр хамрынхаа цаанаас гялалзаж харагдана. Тэр эхлээд цонхон дээр юу болж байгааг сайн анзаарсангүй, өрөөний булан тохой үнэрлэж шалан дээгүүр сүүлээ шарван холхиж байснаа Дэгдүүлэй Бувардай хоёрын үнэрийг авсан бололтой зогтусав. Яг энэ үед гадуур Түнтүүлэй нисч явлаа.

- Та хоёр бас энд юу хийж яваа юм бэ? Сайн үйлс бүтээж байна уу? гэсээр яаран нисч ирэв. Дэгдүүлэй тэссэнгүй онгирч,

- Сайн үйлсдээ бүр баатарлаг үйлс бүтээж байна гэж хэлж амжив. Сагсгар хав тэдний чимээгээр ухасхийн хуцаж, цонхны тавцан дээр өрнөх баатарлаг үйлсэд дургүйцэн, цовхорч зүтгэв. Бувардай Уутхан хоёр цаасан онгоцны зүг харайлгав. Тэдний нэг нь,

- Дэгдүүлэй, түргэлээрэй! Нисье нисье гэж шавдуулна. Цонхны тавцан дээр дөнгөж бугаад учраа ч олоогүй байсан Түнтүүлэй хэмээгдэгч задууль бялзуухай цочиж,

- Яана аа. Нохой байна. Энэ чинь их аймаар баатарлаг үйлс байна гэж хашгираад дэрхийн нислээ. Уутхан яах ч учраа олохгүй тэвдэж байтал Бувардай түүнийг түлхэж онгоцны доорх суудалд суулгаад өөрөө ард нь зүүгдэж нисэхэд бэлэн болов. Дэгдүүлэй тэвдээд дэгээнээс уясан утсаа тайлж чадахгүй л байлаа. Ашгүй, Түнтүүлэй эргэж иржээ. Тэр ухаан сэдэж, сагсгар хавны дээгүүр эргэлдэн нисч анхаарлыг нь сарниулж байв. Гэлээ ч гэсэн тавцангийн доор эргэлдэн хуцаж байгаа сагсгар хав юу юугүй гарч ирээд араас нь зуухаар завдан байгаа мэт санагдан, амьсгаа нь давхцан нүд нь бүртэлзэв. Дэгдүүлэй тэгэхээс тэгж зориуд удаад байх шиг санагдахад тэсвэр алдан торны хаалга уруу гүйж утаснаас угз таттал ашгүй үзүүр нь тайлагдаж газар унав.

Дэгдүүлэй нисэлт дундаа үзүүрээс шүүрэн авч цонхоор гарлаа. Бувардай амжиж Уутханы арын төмрөөс зуурав. Нэг л эгшин хоцорсон бол тэр цонхны тавцан дээр сагсгар хавтай халз тулах байжээ. Онгоц хэдийгээр хоёр тасалгаатай биш боловч тоосон шинжгүй агаарт хөвж, салхины урсгалд үл мэдэг чичигнэн савчиж явлаа. Түүний өмнө нь Дэгдүүлэй айсандаа далавчаа тэнхээ мэдэн дэвж харагдана. Тэднийг Түнтүүлэй огт салахгүй дагана. Тэр:

- Та нарт би тусалсан юм чинь баатарлаг үйлсээсээ надтай хуваалцана биз дээ? хэмээн зогсолтгүй шалах ажээ. Тэд сандраад үг дуугарах сөхөөгүй тул Түнтүүлэй баахан шалж байгаад үүр өөдөө нисэн одов. Аюул өнгөрөхөд эргэн харвал тэдний байсан цонхонд гэрэл асч, сэгсгэр хавны эздийн толгой шоволзон цонх уруу нь ирж байгаа нь харагдав. Жаахан нисээд эргэж харахад тэдний байсан цонхонд тэр айлын гэр бүлийнхэн цөм цугларчихсан, нэг хүү сагсгар хаваа тэврээд Уутханыг газар унасан болов уу гэж бодсон бололтой доош ширтэх нь үзэгдэв. Тэд аажуухан уруудсаар элсэн дээр буух болов. Гэтэл өмнө нь урьдчилан бодоогүй нэг асуудал тулгарав. Цаасан онгоцон дээр хоёул нисч байсан учир газар маш хурдан ойртож балаа. Энэ чигээрээ газар буувал аюултай ажээ. Ингэж байтал ашгүй Дэгдүүлэйн толгойд нэг санаа төрөв бололтой хашаанд байдаг шанаган хорхойт шалбааг чиглэн нисэв. Дэгдүүлэй хар нялхаасаа үргэлж нисч ихээхэн туршлагажсаны хэрэг сая гарав. Шөнө болж тэнгэрт од мичид түгсэн хойно шалбаагт усыг зүсэн бууцаалаа. Аз дайрахад шалбааг төдийлөн гүнзгий биш ажээ. Ингээд шалба норсон гурван амьтан, чүү ай мөлхсөөр эрэг дээр гарч, нойтон биеэ

хатаахаар суув. Намрын дулаахан шөнө усанд тольдох од мичдийг сонирхон суух юутай жаргалтай билээ. Шал пал хийх чимээ харанхуйд сонстож, шанаган хорхой хааяа үсрэхэд сарны гэрэлд гялтганан мэлтэлзэх усны мандал дээр дугариг цагираг үүсч, тал тал тийшээ тэлэн томорсоор замхарч байв. Усны мандал толийход дахиад л од мичид тодрон гарч ирнэ. Дэгдүүлэй усаа сэгсэрч өдөө сагсайлгаад,

- Одоо цөмөөрөө Уутханд гэр олж өгье гэв.

- Би оллоо. Хашааны буланд ёроолдоо хонгилтой өндөр ногоон гацуур ургадаг шүү дээ. Уутханыг тэнд оруулья. Тэгэх үү? гэхэд Дэгдүүлэй:

- Тэгье тэгье, тийшээ явцгаая. Уутханы сэтгэлд яг таарна гэж дор нь дэмжлээ. Уутхан торноос чөлөөлөгдсөндөө маш их баяртай байв. Өөрийн гэртэй болж байгаагаа дуулаад бүр ч их баярлав. Ингээд тэр гурав бут сөөг дундуур шурган, түрүүнд нь Бувардай, араас нь Уутхан, сүүлд Дэгдүүлэй дагасаар орооцолдсон өтгөн харанхуй өвсөн дундуур зүтгэсээр ойролцоо харагдах гацуурын дор тулж ирэв. Харанхуйд харлан харагдах хонгилын амсар уруу сэмхэн гэтэж ойртлоо. Бувардай газар хэвтсэн урт модыг авч төнхөж үзэв. Тэндээс ямар нэгэн амьтан гарч ирсэнгүйд тэр гурав хонгилд зориглон орлоо. Хонгилд хуурай навчис дүүрэн чихээстэй, дулаахан байна. Өвлийн хүйтэнд ч тух алдахааргүй ажээ. Бувардай хонгилын доторх байдалтай танилцаж үзээд,

- Уутхан минь чи үүнээс хойш энд суух болж байна. Шинэ гэр чинь чамд таалагдаж байна уу? Хэрвээ чи тороо санаад байвал би хонгил дотор шинэ тор хийж өгье гэж чин сэтгэлээсээ түүнийг аятай тухтай байлгахыг эрмэлзэн өгүүлэхэд Уутхан баярлахын ихээр баярлаж,

- Ямар сайхан хонгил вэ? Та хоёрт их баярлалаа. Би ийм сайхан хонгил байдаг гэж ер зүүдлээгүй юм. Харин тор хийгээд хэрэггүй. Хэчнээн сайхан тор байлаа ч эрх чөлөөг боогдуулдаг хамгийн муухай аймшигтай зүйл тэр учир торноос холхон явахыг та нартаа зөвлөө гэжээ.



- За тэгвэл энд ширээ сандал хийж тавья. Энд яндан гаргаж, зуух тавья хэмээн Бувардай тоочин нааш цааш алхаж эхлэхэд Дэгдүүлэй яарч,

- Одоо хоёулаа явъя. Нойр хүрч байна гэж яаруулав. Нээрээ ч шөнө дунд болж хамаг амьтан унтсан учир тэд Дэгдүүлэйн саналыг дуртайяа зөвшөөрцгөөв.

## УУТХАНД ЭД ХОГШИЛ ЦУГЛУУЛСАН НЬ

Уутхан хоймроор өвс, навч зулан дэвсэж зөөлөн хэвтэр бэлдээд хоёр гурван далбагар навч нөмөрч дулаахан унтаж байлаа. Нар дээр хөөрч байшингийн нөмөрт суусан тарган тарган тагтаануудыг ээж, бутны сүүдэрт бөнжигнөн нуугдаж буй шүүдрийг аажим аажмаар хөөн гүйцэж наадна. Хүүхдүүд сургуульдаа явчихсан бололтой хашаанд шуугилдах хүнгүй, модны мөчир шилмүүс хөдөлгөх салхигүй тун аятайхан өглөө байлаа. Уутхан сэрээд хонгилын амсраар харагдаж байгаа бут сөөгийг ажиглан удаанаар эвшээлгэв. Торон дотор сонингийн цаасан дээр хэвтэж байснаас энд навчин дээр унтах нь жаргалын дээд болохыг Уутхан мэдэрч байлаа. Шинэхэн танилцсан найз нар нь удахгүй ирнэ гэдэг бодол түүний сэтгэлийг баяр хөөрөөр бялхуулж байв. Орноосоо бушуухан босч хонгилоос гарч үзэв. Эргэн тойрон бут сөөгөөр хүрээлүүлсэн хөвд цэцэг бүрхсэн жижигхэн талбай өмнө нь байна. Шөнө харагдаж байсан арсгар сарсгар бутны мөчрүүд өглөөний наранд шаргалтаж эхэлсэн навчсаа дэлгэн толгой дээрээс нөмрөх ажээ. Уутхан зөөлхөн ногоон хөвдөн дээр ийш тийш чих тавин зогстол,

- Хүүе хүүе, тэр хараач!
- Ууттай юм. Ямар хөөрхөн юм бэ?
- Хаана хаана?
- Тэр ногоон талбай дээр. Тэр гацуурын доор байна. Хараач хараач!
- Битгий шахаад байгаач!
- Юм үзээгүй биш, тайван байцгаа!
- Битгий шахаад байгаач! Энэ нарийхан тэвцэг дээр хаагуур нь зэрөх гэсэн юм бэ? гэх зэрэг янз бүрийн хоолой сонстов. Уутхан

ямар амьтан хэний тухай яриад байгаа юм бол хэмээн гайхан эргэн тойрноо ажтал эсрэг талын байшингийн хананы нарийхан тэвцэг дээр суугаа олон тагтаа, түүний зүг сонирхон харж байлаа. Удсангүй бургас мөчир хөдлөн навчис сэржигнэх чимээ гарч Бувардай ирэв. Тэгтэл ашгүй Дэгдүүлэй ч ирэв. Тэр хатсан навч хийсгэн хонгилын амсар дээр бууж,

- Энэ тагтаанууд чиний тухай яриад байгаа юм уу? гээд тагтаанууд уруу хандаж,

- Энэ миний найз гэж гайхууллаа. Тэд ч юм хэлсэнгүй. Бувардай тэгэхээр нь Дэгдүүлэйг хорьж,

- За за яах гэсэн юм бэ, хоёулаа Уутханы хонгилыг тохижуулья гэвэл харин Дэгдүүлэй,

- Би өнөөдөр чадахгүй. Та хоёр өөрсдөө тохижуул. Би цуглаанд яарч байгаа гэж хэлэв.

- Ямар цуглаантай болоо вэ? гэхэд Дэгдүүлэй хонгилын амсраас,

- Бор шувуунуудад тийм ажил байдаг юм. Өглөө болгон цуглаж маргацгаадаг юм. Би өнөө өглөө бор шувуу Жийвжийвтэй дайралдаж цаасан онгоцны тухай ярьсан чинь намайг "агаарын илжиг" гэж нэрлэсэн. Би цуглаан дээр очиж тэр тухай тайлбарлахгүй бол намайг тэд "агаарын илжиг" гээд тараачихна. Бүх хашаагаар намайг тэгж дууддаг болбол яана гэж нэг их л сэтгэл зовсон шинжтэй хэлэхэд Уутхан түүнийг өрөвдөж,

- Нээрээ тэгвэл чиний ажил чухал юм байна. Яв яв, бид үүгээрээ ажлаа амжуулья гэж зөвшөөрөв. Дэгдүүлэйг нисч алга болоход тэр хоёр хонгилоос гарав. Голио царцааны дуу сонсдон өвсөн дундуур туучин явтал, өмнөх бургас сийрч цаанаас нь машины гараашийн хана гарч ирэв. Гараашийн суурин доороос ёрдойн цухуйж байгаа төмөр хоолойноос жижигхэн булаг ундарч амжилгүй газар шингэж намаг шалбааг болох ажээ. Бүх хүүхэд нүүр гараа угаадаг тул тэр хоёр бас тэдэнтэй адил гар нүүрээ угаав. Том хүрэн чулуу, бут сөөгийг тойрон ногоон нуга уруу ортол үхрийн нүдний бут дайралдав. Зарим нь шарлаж, зарим нь ногооноороо байгаа бутны навчин доороос том хүрэн жимснүүд бөнжигнөн унжиж байв. Тэр хоёр жимс түүгээд цааш хөдлөв. Эргэн тойрон багваахай цэцэг дэлгэрсэн зүлгэн дотор өчигдөр онгоцтойгоо унасан шалбааг харагдав. Тунасан усан дотроос дөнгөж ёрдож байгаа төмөр утсанд наалдсан цаас бол өчигдөрхөн

хөгжилтэй нь аргагүй агаарт хөвөн нисч байсан онгоц мөн билээ. Цааш явсаар хүүхдийн тоглоомын талбайд очив. Тэнд гулгуур, авирч буух шат, савлуур зэрэг хүүхдийн хамгийн дуртай тоглоом байна. Уутхан энэхүү гайхамшигт сонин хотхонд ороод эргэн тойрныгоо алмайран ширтэж явлаа. Хөөрхөн унага, буга, онгоц, пуужин хосолсон эрээн мяраан будагтай эргүүлгэн тоглоомын хажуугаар гартал түүний цаана алтан загас хөвсөн оргилолт булаг байна. Энэ бүгдийг гайхан сонирхож явтал Бувардайгаас хоцорсон байжээ. Түүнийг эрж нааш цааш саравчлан хартал алдартай зодоонч Заваандай гэдэг харх муухай хараад сууж байв.

- Чи хэн бэ? Миний тоглоом дээр яах гэж ирсэн бэ? Яв! гэж түүнийг хөөв. Уутхан түүнээс айгаад юу ч дуугарсангүй. Хажууд нь цувралдан хэвтэж байгаа нуруун дээрээ дүүжинтэй ногоон матруудыг давтал цаана нь ашгүй Бувардай явж байв. Тэр Уутханыг төөрч хоцорсныг анзаараагүй байжээ. Уутхан бушуухан түүнийг гүйцэж очтол,

- Уутхан би чамд хувцасны шүүгээ хийх хайрцаг оллоо. Үүнийг хараач хэмээн гоё хайрцаг үзүүлэв. Нүүрэн дээр нь зурсан сарнай цэцэг нь амьд юм шиг товойн харагдана. Уутхан гоё зурагтай хайрцагт сэтгэл татагдаад саяхан дайралдсан дээрэнгүй амьтны тухай ч хэлэхээ мартан,

- Ямар гоё юм бэ? гэж дуу алдав. Тагийг нь нээж үзээд,

- Ямар сайхан үнэртэй юм бэ? гэж гайхав. Тэр нь савангийн хайрцаг ажээ. Цааш явтал чанамал юүлдэг хоосон шил сав таарлаа. Бувардай түүнийг хараад тоосон шинжгүй,

- Шил саваар ч юу хийх билээ дээ гэж дэргэдүүр нь өнгөрөхөд Уутхан гэнэт санаа сэдэж,

- Үүгээр ор хийе, тэгэх үү? гэж асуулаа. Бувардай шил саван дотор жараахайнаас өөр амьтан байж болдог гэж зүүдлээгүй явсан учир,

- Чанамалын шилээр үү? хэмээн нүд нь орой дээрээ гарч дуу алдлаа.

- Яагаад болдоггүй юм бэ? Дотор нь орчихоор гадагшаа нэвт харагдана. Бүх хонгилоо хараад байгаа мөртөө салхи жавар, харанхуй шөнөөс тусгаарлачихна гэв. Нэг талаар Уутханы бодол яриагүй зөв. Чанамалын шилэн дотор унтаж болохоос гадна хэрэгтэй үед дотор нь юм угааж болох юм гэж Бувардай сэтгээд за тэгвэл ор хийе гэж зөвшөөрөв.

Ийнхүү тэр хоёр чанамалын шилэн савыг гэрийн зүг өнхрүүлж гарлаа. Замд нь Заваандай амдаж байсныг тэд мэдсэнгүй. Бувардай Заваандайн унжуу хамрыг хараад л дотор нь муухайрч хэл нь ээдрэв. Одоо Уутхан түүнийг хулчийж байгааг мэдвэл бүр ичгэвтэр юм болно гэж мэдэж байсан боловч хоолой нь өөрийн эрхгүй чичирч,

- Аа, Заваандай гэж өөрийн эрхгүй дуу алдав.

- Та хоёр яагаад хог түүгээд яваа юм бэ? Наад юмнуудаа энд орхиод тонилцгоо. Миний юм байна. Та нарыг дахин үүгээр үзэгдэх юм бол хамрыг чинь дэлсэнэ шүү гэж заналхийлээд Бувардайн өмнүүр нударгаа доёлзуулан сүр бадруулав. Бувардай юу хэлэхээ мэдэхгүй бүлтэгнэж байтал Уутхан ярианд оролцож,

- Чинийх юм бол аваад гэртээ харихгүй яасан юм бэ? Чи худлаа ярьж байна. Харин чи Бувардайг дэлсэх юм бол би Дэгдүүлэйд хэлнэ гэв.

- Дэгдүүлэй гэдэг чинь хэн юм бэ? гэж Заваандай жаахан хулчийсан шинжтэй болгоомжлон лавлав.

- Дэгдүүлэй гэж үү? Дэгдүүлэй гэдэг энэ дээ гээд өөрийг нь дуурайж нударгаа зангидаж үзүүлэв. Заваандай сүрджээ.

Тэгээд бууж өгсөн байдалтай,

- За за та хоёр, юмаа аваад бушуухан зайл гэж зандрах үглэхийн завсарт гүвтнэв. Хоёр найз замаа цааш үргэлжлүүлтэл, Заваандай хойноос нь дуудаж,

- Наад шилээрээ юу хийх гэж байгаа юм бэ? гэж хашхирлаа.

- Ор хийнэ гэж хариулахад,

- Ор оо? гэж давтаад болхидуухан инээж,

- Та хоёр хогийн савнаас юм аваач. Тэнд энэ байтугай жинхэнэ ор байдаг юм. Ээ, мангарууд гэж хэлээд яваад өгөв. Тэр хоёр гэртээ ирээд савангийнхаа хайрцагт сүрлээр хөндлөвч хийж хувцас өлгөх өлгүүр хийв. Чанамалын шилийг Уутханы унтах хонхорт байрлуулан дотор нь өвс навч дэвсэн зөөлхөн дэвсгэртэй ор болголоо. Тэр хоёрыг хонгилоо тохижуулж дуусч байтал Дэгдүүлэй орж ирлээ.

- Дэгдүүлэй цуглаанаасаа ирж байна уу? Жийвжийвийг дийлсэн үү? гэхэд,





- Бүү мэд! Манай байшингийн нөмөрт хэсэг болжмор сууцгаагаад янз бүрийн юм ярилцацгааж байтал Жийвжийв нисч ирсэн. Тэр намайг мартсан бололтой өөр юмны тухай яриад байна билээ. Тэгээд л удалгүй болжморууд тарж нисэцгээсэн. Би ганцаараа тэнд юу хийж суух билээ, наашаа ирж байгаа минь энэ гэв. Би замдаа ийм зураг оллоо гээд шуудангийн марк үзүүлэв.

- Энэ юу юм бэ? гэж Бувардайг гайхан асуухад Уутхан тосон авч,

- Би мэднэ. Энэ бол шуудангийн марк гэдэг юм. Намайг басилгээмжээр явуулахдаа ийм марк наагаад явуулсан юм. Захиан дээр

наахаар хаана ч хамаагүй аваад явуулчихдаг юм гэж тайлбарлав. Тэр гурав тэмээний зурагтай маркаа хананд наахдаа Уутханы хонгилыг аваад явчихгүй байгаа гэж болгоомжилж ямар ч гэсэн сул өлгөв. Бувардай, Дэгдүүлэйд Заваандайтай тааралдсан тухайгаа хэлсэнгүй. Уул нь Заваандай дээр л ийм марк наачихвал хааш нь ч хамаагүй аваад явчихна байх даа. Тэр гэртээ буцах замдаа "Турьгүй бяцхан Уутхан баатарлаг үйлс бүтээж байхад би яагаад Заваандайгаас айв" хэмээн шаналан бодсоор гэлдрэв. Тэдний гадаа мөн л байдгаараа олон хүн нааш цааш хөлхөлдөж хонгилын амсар дээр ургадаг багваахай цэцэг цайран малгайлж, салхины аясаар будран хийсч байлаа.

## ДЭГДҮҮЛЭЙГИЙН ОЙ ДЭЭР

Байшингийн дээврээс гоожсон борооны усны захаар мөс зайрмагтан хөлдөж, намар орой болжээ. Удахгүй өвөл болно. Хамаг амьтан өвлийнхөө бэлтгэлийг хийнэ. Хэдий тийм боловч Бувардай Дэгдүүлэйтэй нийлээд хэдэн хоног өөр ажил хийв. Учир нь, Дэгдүүлэйтэй уулзахаар өдөр бүр цаасан онгоц хийж нисч чаддаггүй байв. Дэгдүүлэй байхгүй бол онгоц нисч чадахгүй шүү дээ. Бувардай анх удаа нисч байшингийн дээвэр, олон сайхан байшин, тэртээд харагдах уул хөндий, малчдын цагаан гэрүүдийг харснаас хойш

Дэгдүүлэй, Түнтүүлэй, Жийвжийв нарт атаархаж, тэд яагаад тийм их нисэх дуртайг ойлгожээ. Ингээд ядахдаа байшингийн дээвэр дээр дуртай цагтаа гардаг болохын тулд гурван найз ус гоождог хоолой дагуулан дээвэр хүрдэг дүүжин бүтээв. Харин өнөөдөр хамаг ажлаа гүйцээсэн тул жаахан амарч байгаад “Өвлийн бэлтгэлээ хийдэг юм уу” гэж бодож суув. Гэтэл Уутхан орж ирэв. Тэр Дэгдүүлэйгийн ой өнөөдөр болж байгааг сануулав. Тэднийд очихоор гарах гэтэл,

- Чи хоосон очих гэж байгаа юм уу? Төрсөн өдрийн баяр болж байхад найзыгаа баярлуулах бэлэг хэрэгтэй шүү дээ гэж Уутхан хэлэв.

- Тийм үү, би ямар бэлэг өгөх вэ? гэж Бувардайг сандран асуухад Уутхан хонгилын амсар дээр орхисон боодолтой юмыг задалж дотроос нь гоё улаан товч гаргаж үзүүлээд би товч бэлэглэнэ гэж хэлэв.

- Товч бэлэглэж болдог юм уу? Тэгвэл би юу бэлэглэх вэ? Сүлбээр зүү бэлэглэвэл ямар вэ? Өд нь унах гээд байвал хатгачаад явж байхад хэрэгтэй юм. Тийм үү? Товчноос дээр гэж ярихад Уутхан толгой сэгсэрч,

- Миний энэ товч гоё болохыг анзаарахгүй байна уу? Төрсөн өдрийн баяраар найздаа гоё юм өгөх хэрэгтэй гэв.

- Тэгвэл саатай тууз сүлбээрэндээ хатгачихъя. Тэгээд л гоё болно гэж Бувардай хэллээ. Тэгээд дүүжин хайрцагтаа очиж суув. Тэр хоёр хайрцагны голд байгаа дамрыг эргүүлэхэд утас хураагдаж дүүжин хайрцаг дээш явна. Тэр хоёрын суусан хайрцаг дээврийн дор байдаг нүхэнд тулж ирэхэд сандарч байж дээвэр доор оров. Тэнд шувуунуудын гэр байдаг юм. Дэгдүүлэйн үүр хамгийн ойрхон оршдог. Тоосгон хашлагын цаад мухарт бамбагар зөөлхөн үүр харагдана. Шувуунууд үүрээ л сайн хийхээс, зам засна гэдгийг мэдэхгүй амьтад л даа. Дэгдүүлэйн зөөлхөн үүрэн дээр хэчнээн ч өнхөрсөн болно. Дэгдүүлэй тэднийг ирэхийг үзээд баярлан хашхирч,

- Та хоёр юу хийж яваа юм бэ, алив хурдан ороод ирцгээ гэв.

- Бид хоёр чиний ойд ирж байна.

- Миний ой юм уу? Өнөөдөр миний ой болж таарлаа шүү. Би андуураагүй байх нь гэж их л сэтгэл хангалуун хэлэв.

- Би өнөөдөр миний төрсөн өдөр мөн билүү, биш билүү гээд та хоёрыг урих уу яах вэ гээд сууж байсан чинь ашгүй өөрсдөө мэдээд ороод ирлээ гэж баярлав. Бувардай Уутхан хоёр ч бэлгээ өглөө.

- Дэгдүүлэй май. Миний бэлгийг ав. Энэ улаан товчийг үүрэндээ

хадаарай. Бид чиний үүрийг харанхуйд ч болов олж байя гээд Уутхан бэлгээ гардуулав.

- Май гэж Дэгдүүлэй бас сүлбээр зүү өгөв. Энэ миний бэлэг шүү. Саатай тууз хатгасныг нь харж байгаа биз хэмээн анхааруулав. Баярласнаасаа болоод Дэгдүүлэй хэлэх үгээ олж ядаж байв. Бувардай түүнээс,

- Чи баярлаж байна уу? гэж асуухад,

- Хязгааргүй их баярлаж байна гэж Дэгдүүлэй үнэн голоосоо хэлэв.

- Тэгвэл жинхэнэ ой болж байгаа нь энэ дээ гэж Бувардай сэтгэл хангалуун хэлэв. Дэгдүүлэй тэр хоёрыг хэр чадлаараа зочлов. Гэтэл Түнтүүлэй нисч ирлээ.

- Та хоёр дээвэр дээр яаж гарч ирсэн бэ? гэж мэнд ус ч үгүй буув. Тэр гурвын дунд байгаа амттаныг хараад асуултынхаа хариуг ч авалгүй,


- Алив Бувардай жаахан цаашаа суугаач. Зочин ирж байхад чинь ямар ичдэггүй юм бэ? гээд шахан суув. Түнтүүлэй Уутханыг дуурайж уут зүүжээ. Тэгээд уутныхаа хэргийг гаргаж, нэг атга самар авбал хагасыг нь идэж үлдсэнийг ууталж байв. Тэд дуулцагаасаар байв. Ганцхан Түнтүүлэй дуулсангүй. Яагаад гэвэл тэр боов үмхлээд завгүй байлаа.

Орой болов. Гаднаас тагтаанууд сүрэг сүргээрээ нисэн ирцгээнэ. Тагтаанууд тэдний дуулахыг огтхон ч тоосонгүй, ангаахай уруугаа яарцгаана. Таваг хоосрох дөхөж ирэхэд Түнтүүлэй яарч явлаа гэж хэлэх гэсэн боловч хэтэрхий их самар жимс дээр дээрээс нь яаран чихсэнээс болж зогьсуулаад юу ч дуугарч чадахгүй байлаа. Юм хэлэх гээд,

- Хиг хог гэж дуугараад байх тул уутаа аваад чимээгүйхэн нислээ. Гэтэл уутандаа дүүргэсэн боов шоовондоо дийлдэж гаднаас орж ирсэн Жийвжийвтэй мөргөлдөж газар унав. Жийвжийв уурлан,

- Замаа харж нисэх нь яадаг юм бэ? Нисдэг амьтад цөм замаа харахгүй байвал энэ дэлхий дээр юу болно гэж бодож байна хэмээн загнаж, өдөө сэгсэрч тоосыг нь унагаагаад Түнтүүлэйг сая анзаарч,

- Энэ чинь хаанахын үүргийн худалдаанд ажилд орчхов? Ямар их самар хааш нь зөөж яваа юм бэ? гэж дуу алдав. Түнтүүлэй газар унахдаа самраа ойр хавиар цацаж орхиод тэлчилж хэвтэв. Тэр үг хэлж чадахгүй зогьсуулсаар байв. Жийвжийв Түнтүүлэйг шоолж нүднээсээ нулимсаа гоожтол хөхөрлөө. Тэр Дэгдүүлэйн үүрэн дээр



өнхрөн хөрвөөж инээж гарахад Бувардай, Уутхан, Дэгдүүлэй нар ч тэсэлгүй түүнийг даган баахан инээлдэв. Жийвжийв инээж байснаа больж,  
- Юу? гэж асуув. Тэд нар юу хэлэхээ мэдэхгүй тулгамдан байтал Бувардай Түнтүүлэйн хэвтэж байсан газар өөд заан,  
- Ээ... э гэхэд Жийвжийв ёстой нэг бах нь ханаж байгаа бололтой хөхөрч гарав.

- Хэдэн цаг болж байна? гэж гэнэт асуухад Уутхан сая инээдээ барьж,

- Нар жаргачхаж гэхэд Жийвжийв ярина.

- Тэгвэл би гэртээ харилаа. Намайг нэг бор шувуу хүлээж байгаа.

За баяртай гээд нисч бүрэнхий хонгилд бараа тасрав. Бувардай, Уутхан хоёрыг Дэгдүүлэй гаргаж өгөв. Гадаа бүрэнхий болж тэнгэр гүн цэнхэр өнгөөр туяаран энд тэнд том том од борооны дусал шиг бөнжигнөж байв. Намрын дөлгөөн орой гудамжаар хүмүүс дуртайяа зугаална. Дэгдүүлэйн ой маш сайхан болж өнгөрөв.

## БУВАРДАЙ УУТХАН ХОЁР ГЭНЭДСЭН НЬ

Гадаа сэрүүхэн байлаа. Бувардай эртлэн босоод дулаан хувцсаа өмсч гарав. Гудамжнаа ганц нэг хүн яаран алхаж, талхны дэлгүүрийн өмнө талын талбайг хөх халаадтай цэвэрлэгч шүүрдэх нь үзэгдэнэ. Өөр хүн амьтан харагдахгүй намуухан байлаа. Нар гарах болоогүй учир тэнгэр газар, уул мод, байшин, эргэн тойрон цагаан цэнхэр өнгөнд умбажээ. Навч нь унаж эхэлсэн улиасны орой дээр шал нойрмог хөх бухандай зүүрмэглэнэ. "Заваандайн зааж өгсөн хогийн сав уруу Уутханыг аваад очъё" гэсэн бодол гэнэт Бувардайд төрөв. Тийнхүү Уутханых уруу чигээрээ очвол тэр дөнгөж босоод чанамалын шилэн дотроо ороо хурааж байв.

- Хөөе Уутхан, хоёулаа Заваандайн заасан хайрцагт орж үзье. Өвлийн бэлтгэлээ базаая. Тэгэх үү? хэмээн Бувардай амьсгаадан өгүүлэв.

- Заваандай дандаа болохгүй юм хийж урагшгүй үйлс гаргадаг биш үү? Түүний үгэнд орж балрах хэрэг байна уу? гэж Уутханыг эргэлзэхэд,

- Юу ч гэсэн очиж үзье. Юу нь муу байгаа юм бэ? Орж үзчихээд худлаа ярьсан байвал яваад өгнө биз гэж Бувардайг буцах шинжгүй шалахад тэр нэг их цааргалсангүй. Тэгээд тэр хоёр өвлийн бэлтгэлээ базаахаар хамтран хөдлөв. Хогийн саван дээр очиход дорно зүгээс тэнгэрийн хаяа улайрч байлаа. Бувардай Уутханыг дагуулж хоосон шил сав, хайрцагны дундуур мөлхсөөр хогийн саван дээр гарав. Тэнд элдэв юмс хэвтэнэ. Тэд өвлийн бэлтгэлд хэрэг болчхоор юм цуглуулж байтал гэнэт машины дуу гарлаа. Булангийн цаанаас энэ хайрцгийг аваад явчихдаг, дээрээ дэгээтэй машин харагдаж тэдний зүг чиглэн давхина. Бувардай юу болж байгааг тэр дор нь гадарлаж, аюултай савнаас гарахаар Уутханыг дагуулан доош гүйлээ. Тэр хоёр нэг нэгэндээ тээглэн мөлхөх газраа мөлхөж, харайлгах газраа харайлган явсаар хайрцагны ёроолд ирэв. Бувардай сандарсандаа битүү байсан булан уруу буусан байжээ. Айж сандран буцаж мөлхөв. Нэг мэдэхэд Уутхан алга болсон байлаа.

Машины дуу улам чангаран тэр хоёрын байгаа савны дэргэд зогсоод хогийн хайрцгийг ачлаа. Тэгээд тэднийг аваад цааш давхилаа. Замын донсолгоонд хогийн хайрцаг дотор шил төмөр хавиралдан энд юм хагарах, унах чимээ сонстож бөөн тоос босч байлаа. Бувардай Уутханыг савнаас гарч амжсан болов уу, яасан бол хэмээн сэтгэл зовохын зэрэгцээ толгой дээрээс нурах элдэв хайрцаг саванд дарагдахгүйн тулд бушуухан хогийн хайрцаг дээр авирч гарав. Хогийн хайрцаг дээр байгаа цааснууд салхинд салбаганана. Хоёр талаар өндөр байшин жирэлзэн өнгөрнө. Савны амсар дээр Уутхан гарч ирсэнгүй. Тэр савнаас гарч амжсан юм болов уу даа. Бувардай донсолгоонд суга үсрэн хаягдахгүйг хичээж, хаягдсан бээлийн дор нуугдаж, айж сандарсандаа түүнийг авч яваа машин хаашаа явж байгааг анзаарсангүй. Нөгөө машин, дээрээ ачсан хайрцагнуудаа торжигнотол дуугаргасаар цардмал замаас гарч их уулын хормойд ирж зогслоо.

Бувардай ч хайрцгийг газар буулгахаар гарсугай хэмээн сэтгэж хайрцагны ёроол уруу мөлхөв. Хоёр гурван хайрцаг лав газар буулгах шиг болов. Дараагийн эгшинд Бувардайн суусан хайрцаг дэнжигнэн

өргөгдсөнөө гэнэт урвуугаа хөмрөн хамаг хогоо доош асгав. Машин ч яваад өгөв. Эргэн тойрон чив чимээгүй дүнсийнэ. Бувардай хөл дээр дараад байгаа зүйлийг тийрэн зайлуулж өндийвөл ойр хавь хүн, амьтангүй хөдөө газар ирсэн байв. Энд тэнд хагархай шил гялалзана. Бувардай сүү, загасны хоосон хайрцгийг хангир жингэр нураасаар хог дээрээс буув. Гэтэл түүний хажуугаар дөнгөж тогтож байсан төмөр лааз доош өнхрөн буухад дотроос нь ямар нэг юм шидэгдэн үлдлээ. Тэр юу юугүй тонголзон хөдөлж, босоод ирэв. Бувардай цочиж зог тустал Уутхан байлаа.

- Ямар их аз вэ? Бид хоёр хоёулаа амьд үлджээ. Эргэн тойрон юм нурж хачин аймаар байлаа шүү гэж Бувардай дуу алдахад

- Чи бас үлдсэн үү, бид хоёр ямар их азгүй юм бэ? Заваандайн үгэнд ороход ийм л юманд хүргэх байжээ. Би ч яахав энэ лаазанд ороод нүдээ аниад л суучихсан гэж тайлбарлав. Бувардай Уутхан хоёр овгор дээрээс бууж хотгорыг даган алхав. Ингэж явахдаа л тэд хашааны мухарт байдаг хачин жигтэй хайрцгийг хааш нь аваад явчихдагийг мэдэж авав. Тэр хоёрыг алхаж явтал гэнэт тэдний араас,

- Цагаан юм гэж шивэгнэх дуулдав. Бувардай хэн ярьж байгааг мэдэх санаатай эргэж харахад юу ч харагдсангүй.

- Ууттай юм гэж шивэгнэх нь сонстсоор байв.

- Хараач хөөе, гуталтай юм гэхэд Бувардай Уутхан хоёр дулаан гутал уруугаа өөрийн эрхгүй харцгаав.

- Тэр хөөе, эргэж харлаа. Айж байх шиг байна. Би улам айлгаатахъя гэх чимээ сонстсоор төдөлгүй дээрээс тоос манарган чулуу ирж буулаа. Бувардай хэн ингэж шоглоом хийгээд байгааг олох санаатай дахин эргэж харахад барилгын хог асгасан газар ганцаархнаа найгах ерхөгнөөс өөр хөдлөх юм олж харсангүй. Цаашаа эргэтэл хойноос нь адтай нь аргагүй инээлдэх дуулдав.

Тэр хоёрыг нэг овгорыг тойрон гарч иртэл үлийн цагаан оготнууд амдаж байгаад барьж авлаа. Нэг хэсэг нь урагш татаж байхад нөгөө хэсэг нь хойш татаж нэг нь цээж үрүү ёврон нөгөөх нь нуруу уруу түлхэж нэлээд ноцолдов. Тэгээд ч тэднийг унагаж чадсангүй босоо чигээр нь хүлж орхижээ. Үлийн цагаан оготнуудын орилолдож байгаагаас ойлгоход толгойлогч нь алга байв. Тэр хоёрыг түлхэж ёворсоор олон нүхний дундаас хамгийн томынх нь амсар дээр авчрав. Тэдгээр оготно янз бүрийн дэмий юм ам амандаа орилолдох ажээ.



- Ямар цагаан юм бэ? гэж нөгөө л үг сонстох хооронд,  
- Гэрэл үзэхгүй нүхэнд байсаар ийм цагаан болчихдог юм гэж мэдэмхийрэх дуу хадна.

- Чи яаж мэддэг юм бэ?

- Би мэдэхгүй яах вэ? Өвсний түрүү ногоон байхад үндэс нь цагаан байдаг шүү дээ гэхэд бөөгнөрсөн оготны нөгөө талаас,

- Хилийн шугам зөрчсөн байна билээ. Наадуулынхаа толгой дундуур татаад ав гэх дуу хадаж байв. Тэр нь нэг бүдүүн оготно бусдын араар гүйж учир утгагүй хашгирч байлаа. Зарим нь зүгээр л ухаан жолоогүй алмайран ширтэнэ. Өрвөгөр үстэй эдгээр оготнууд Заваандай шиг зэвүүн муухай амьтад санж. Тэдний дотроос нэгэн хазгар оготно:

- Толгойлогчийг дуудсан уу? гэж хашгирахад нөгөөдүүл нь гэнэт санаа авч,

- Харин яасан бол, дуудсан уу? Дуудъя, алив гэгцгээн шуугилдаж нөгөө том нүх үрүү нэг нэгтэйгээ уралдан зүтгэж, чадалтай нь чадалгүй нэгийнхээ толгой дээгүүр харайлган гүйлдэцгээв. Нэгэн зэрэг нүхний амсар уруу олуул ухас хийсэн учир ганц ч оготно орж амжсангүй нүхний амсар дээр чихцэлдэв. Тэгж тэгж хүчтэй нь сугарч ороход хүч султай нь сүүлдэн бусдадаа гишгүүлсэн нэг нь мөлхөн тэр нүх үрүү орж эхлэв. Энд хамгийн сонирхолтой нь оготно бүр "би би" гэж орилолдох нь толгойлогчдоо магтуулахыг л хичээсэн

бололтой. Ингээд тэр хоёрын дэргэд олон хүчтэнд ямбий болтлоо гишгүүлээд нүхний амсар уруу чүү ай мөлхөж яваа хазгар оготно л үлдсэн байв. Тэр оготно хамгийн түрүүн толгойлогчид очъё гэж санал гаргасан билээ. Хэрвээ тэр хоёрыг хүлж хаяагүйсэн бол зугтаад явчихад юу ч саад болохгүй байлаа. Нөгөө хазгар оготныг арай ядан мөлхсөөр нүхний амаар дөнгөж орох гэтэл түрүүний орсон оготнууд толгойлогчийн хамт буцаж гарч ирэв. Хөөрхий муу хазгар оготныг бусад нь анзаарсангүй дээгүүр нь шороотой хутгалдуулан туучна.

- Би барьсан юм.

- Худлаа ярь! Би нааш нь авчирсан юм.

- Би хөл уруу нь өшиглөсөн л дөө.

- Би түлхсэн юм.

- Чи яаж түлхэх вэ дээ. Би түлхэж байсан юм чинь гэх өндөр нам дуу чих дөжрүүлэв. Толгойлогч нь гэж салга толгойтой оготно тэр хоёрыг тойрон шиншилж үзсэнээ,

- Пөөх! Цагаан юм байна гэж дуу алдав.

- Тийм тийм би хэлсэн шүү дээ. Би хамгийн эхэнд хэлсэн гэх дуу дахин чангарав. Нөгөө толгойлогч бах нь ханасан бололтой,

- Ямар хэрэг хийсэн бэ, хөөө хулгайлсан уу? гэж асуув. Бувардай хариу хэлэх гэж амаа ангайтал,

- Хулгайлсан юм. Үгүй хулгайлаагүй юм. Наадуул чинь сар шувууны тагнуул. Үгүй юун тагнуул гэж, баригдсан юм гэх замбараагүй орилолдох дуу дэргэдээс нь чих дөжрөөв. Толгойлогч тэр замбараагүй орилилдоон дунд духаа үрчийлгэн толгойгоо санжгануулан бодлогошрон зогссоноо гэнэт,


- Ууттай юм аа гэж хэлэхэд,

- Тийм тийм, би хэлсэн шүү дээ гэх дуу чангарав, Толгойлогч,

- Ууттай юм чинь дахиад хөөө хулгайлж магадгүй гэж үглэсэнээ,

- Энэ хоёрыг хоёуланг цаазаар... гэж шүлсээ үсэргэн сүртэй хашгирахад тэр хоёрыг хүрээлэн тойрсон оготнууд дуу тавин орилолдоцгоож, зарим нь хүлээсийг тайлж эхлэв. Уутхан олсонд үрэгдсэн

гараа илж уйлахын наагуур эргэн тойрноо балмагдан харж байлаа. Бувардай түүнийг зоригжуулж гарыг нь сэмхэн атгав. Нэг хэсэг оготно



цаазлах гэж дүүжлүүр бэлтгэж байхад толгойлогчийнхоо хэлснийг олны шуугианд ойлгоогүй зарим нэг нь өлгүүрийг буулгаж байв. Нэг мухар сүүлтэй оготно тэднийг тойрон "толгойг нь авна" гэж сүх барин байдаг чадлаараа хашгирч байна. Нэг дүлий бололтой оготно тэднийг хүндэт зочид гэж ойлгосон бололтой хаанаас ч юм цэцгийн баглаа олчихсон гардуулах гэж оролдоно.

Энэ үед бусдад хоёр удаа гишгүүлж хүч тамираа алдсан хазгар оготно тэдний дэргэд мөлхөн ирж сулханаар,

- Би хамгийн түрүүн толгойлогчийг дуудъя гэсэн юм гэж хэлтэл нөгөө олон оготно нэг нэгийгээ түлхэж,

- Би хэлсэн юм, би санасан юм, үгүй би гэлцэн орилолдож байтал сэтгэлийн хөдөлгөөнтэй нэг оготно дэргэдээ зогссон нөхрийнхөө хамар уруу нударгалснаас хөвдөнд оч үсэрсэн мэт дүрэлзэн бүх нийтийн зодоон болов. Нэг том биетэй оготно андуураад толгойлогчоо өнхөрч унатар цохиод унасан хойно нь таньж амаа барихад өөр нэг шалмаг оготно түүнийг шургаж унатар нь дагз уруу нь нударгалж харагдав. Тэр хоёрыг харж цагдаад байгаа оготно ер байсангүй. Цөм зодолдоно. Хоёр найзад ч энэ зодооныг хараад зогсох хэрэг байсангүй. Тэр хоёр сэмхэн зугатаад нэлээд хол явсныхаа дараа сая нэг аврагдлаа гэдэгтээ итгэв. Нөгөө оготнуудын зодоон юугаар дууссаныг бүү мэд.



## БӨМБӨЛГӨӨР НИССЭН НЬ

Маргааш өглөө нь цас бороо холилдон орж байхад Бувардай сэрэв. Уутхан Бувардайд наалдан атирч, тавтайхан унтаж байлаа. Тэр Уутханыг сэрэхэд баясгалантай боссон боловч эргэн тойрныгоо үзэж, гэрээсээ хол байгаагаа санаж гунихран санаа алдав. Өчигдрийн оготнууд тэднийг юу юугүй барьж авахаар нэхэн хөөж байгаа билээ. Иймээс Бувардай тэр хоёр эндээс оргон зайлах аргаа сүвэгчилж эхлэв. Тэд чигээрээ явах юм бол ямар ч гэсэн оготнуудын хотод очихгүй байх гэж хэлэлцэн өндөр уулын зүг алхав. Зам дээр хэвтэх улаан резин байхыг авч борооноос хамгаалах санаатай нөмөрснөө



гэнэт баяраар ийм резин бөмбөлгийг хүүхдүүд хөөргөн явдгийг санацгаав.

- Уутхан! Бид хоёрын нөмөрч бангаа резин чинь нисдэг бөмбөлөг мөн үү? гэж шалчгар резин доор хөл нийлүүлэн алхах замдаа Бувардай асуув. Уутхан резиний үзүүрээс сунгаж үзээд,

- Тийм байна. Баяраар нөгөө хүүхдүүдийн хөөргөдөг бөмбөлөг байна шүү дээ гэж нүд нь сэргэв.

- Хоёулаа дээр нь суугаад хөөрөх юм сан. Тэгвэл гэртээ амархан очно доо гэж мөрөөдөнгүй хэлэв. Уутхан түүний үгийг сонсоод зог тусаж,

- Нээрээ үүнийг бөмбөлөг болгох юм сан. Яаж бөмбөлөг болгодог юм бол? Дотор нь юм хийхгүй бол энэ чинь шалчийчаад байна шүү дээ гэв.

- Харин ээ! Яаж үүнийг бөмбөлөг болгодог юм бол? Уг нь ус дүүргэчихвэл лав бөмбийнө байх даа?

- Борооны усаар дүүргэж болохгүй юу? Мөд дүүрэхгүй л дээ.

- Тэгвэл дотор нь шороогоор дүүргэчихье.

- Шороо хүнд юм чинь лав хөөрөхгүй. Хөнгөн юмаар л дүүргэх хэрэгтэй. Хүүхдүүд үүнийг юугаар дүүргэж бөмбийлгөдөг юм бол? Арай агаараар дүүргэдэг юм биш биз? хэмээн бодлогошрон байв. Уутхан гайхаж,

- Агаар баригддаггүй юм чинь түүгээр яаж дүүргэх вэ? хэмээн зэмлэнгүй дуу алдахад,

- Үлээгээд л дүүргэчихгүй юу гэж уцаарлангуй үглэснээ Бувардай өөрийнхөө амнаас гарсан үгэндээ ихэд гайхаж,


- Нээрээ үлээгээд л бөмбөлөг болгочихъё гэж нүд нь сэргэж ирэв.

- Тэгвэл ниснэ байх шүү. Нөмөрт орж сууя. Бушуухан үлээж үзье гээд тэр хоёр зөв идэж өгөршсөн зуухны нөмөрт орж бөмбөлгөө ээлжлэн үлээж гарав. Утасны тасархай олж дэргэд байсан хатуу цаасан хайрцагтай холбож бөхлөн уялаа. Том улаан бөмбөлөг нисэхийг завдан савчиж газар гуядаж байлаа. Бувардай нэг гараараа хайрцагнаас, нөгөө гараараа зуухны амнаас алдлан зуурч Уутханыг хайрцагт орж суутал нисгэхгүй тогтоон зуурч байв. Бөмбөлөг савчих бүр шилний хагархай уруу гуядаж хагаруузай хэмээн сэтгэл зовно.

Бувардай зуухны амыг тавьж бөмбөлгийн доорх хайрцагт үсрэн орлоо. Тэднийг нисэх үед хүйтэн бороо шавшихаа болив. Чийгтэй салхинд туугдан том улаан бөмбөлөг тэр хоёрыг аван хөгжилтэй нь аргагүй нислээ. Эхлээд газар шүргэх шахам доогуур нисч байснаа аажмаар өндрөө аван улам улам дээшээ хөөрөв.

Тэр хоёр хөөрөн хөөрсөөр нэгэн өндөр уулын орой дээгүүр гарч ирэв. Бувардай уул мөргөж магадгүй гэж болгоомжлон ойр хавийн юмыг маш хянамгай ажиглаж байлаа. Хийн бөмбөлөг өндрөө алдсангүй улам дээш хөөрсөөр байв. Өндөр уулын цаана тэдний танил байшин сав, гэр хашаа, цоохортон харагдана. Салхи ч хотын зүг бөмбөлгийг зугуухан боловч тууштай хөөж байгааг тэр хоёр ойлгож баяртай байлаа. Удсангүй уулын хавтгай орой тэдний доогуур аажим аажмаар гулган өнгөрч нэг мэдэхэд газар доошилж улам холдсоор байгааг Бувардай анзаарав. Ингээд уулын оройг саадгүй даван хотын зүг нисэцгээв.

Удалгүй хотын захын хашаа байшин, гэрүүд харагдаж эхлэв. Түүний наагуур адуу мал багширч, малчдын цагаан гэрүүд уулын суга бүрт цайрч харагдана. Хургаа хариулсан хүүхдүүд ногоон зүлгэн дээр чулуугаар тоглож байна. Машины зам нарийхан хар тууз шиг харагдана. Хотын дээгүүр нисэхэд барилга байшингууд хүүхдүүдийн элсэн дээр барьсан цамхгийг санагдуулна. Тэднээс холгүй телевизийн улаан эрээн цамхаг сүндэрлэн түүний цаагуур шинэ хорооллын өндөр өндөр байшингууд дүнхийцгээнэ. Хотын шавааралдсан олон байшин дотроос өөрсдийнхөө хашаа байшинг эрсээр явтал нэг мэдэхэд тэдгээр байшин үйлдвэр, агуулахаар солигдож эцэст нь хотын захаар урсдаг гол харагдахад сая хот дээгүүр шувт нисээд өнгөрч байгаагаа анзаарав.



Уутханы толгой эргэж хайрцагны ирмэг дээгүүр харах сөхөөгүй, дуу шуугүй буланд цомцойн суух тул энэ тухай мэдээгүй л байлаа. Бувардай гаргасан алдаагаа засах гэж бөмбөлгөө доош нь хэчнээн татавч ер буулгаж чадсангүй.

Салхи тэдний суусан бөмбөлгийг улам улам урагш нь голын цаана гаргахаар хөөж байлаа. Бөмбөлгөө хагалж хийг нь гаргаж болох л юм даа. Тэгвэл аяндаа шидсэн чулуу шиг газар уруу хар эрчээрээ явах нь мэдээж. Харин амьд үлдэх үү гэдэг их эргэлзээтэй юм. Иймээс Бувардай хийн бөмбөлгийг хагалж зүрхэлсэнгүй. Түүнийг буух аргаа сүвэгчилсээр байтал голын цаад эрэг дээгүүр нисч явлаа. Тэртээ доор гол олон салаалан мурилзан урсаж түүний эргээр бургасан шугуй найгана. Ингээд Уутхан Бувардай хоёр

хашаандаа хүрч чадсангүй, өмнө зүг салхинд туугдан ниссээр байв. Бувардай бүр санаагаар унаж хаашаа нисч байгаагаа анхаарахаа больж хайрцагтаа орж урамгүйхэн суухад,

- Яасан бэ? Бувардай! Бид нар буух болоогүй юу? гэж Уутхан ядарсан дуугаар асуув.

- Болох нь болсон л доо. Бууж чадахгүй байсаар бүр өнгөрөөд явчихлаа. Шүхэртэй сэн бол үсрээд буучихмаар байна. Ядахдаа Дэгдүүлэй нисээд явж байдаг болоосой гэж халаглан үглэв.

- За яая гэх вэ? Битгий сэтгэлээр уна. Явж байгаад учир нь олдох байлгүй. Нэгэнт өнгөрсөн юмны хойноос сэтгэлээр унаж байснаас тэр үүлийг хараач! Ямар гоё юм бэ? Яг лусын хааны ордон шиг. Чи тэр шилтгээний хаалга шатыг олж харав уу? Наад талаар нь их өтгөн ой, цэцэрлэг байна. Одоо бид яг тэр шилтгээн уруу нисч явна гэж цомцойн суугаад хайрцагны ирмэг дээгүүр харагдаж байгаа үнэхээр сүрлэг зузаан үүлийг заав. Тэр үүлний хажуу бөөрнөөс нарны гэрэл тусч үлгэрийн орон шиг болгожээ. Бувардай Уутханыг айж уйлна байх гэж бодсон чинь харин нөгөөдөх нь түүнийг энэ хүнд цагт тайвшруулах

гэж сэтгэлийг нь засахыг оролдож байгааг хараад үнэхээр гайхан яриаг нь бишрэн сонсч байлаа.

-Бид хоёр ниссээр шууд тэр мөнгөн цагаан шилтгээний шатан дээр буухад биднийг хурмастын хаан угтана. Тэнд өвс ногоо, бут шугуй, гол ус бүх юм нь сувдан цагаан өнгөтэй. Сувдан цагаан танхимдаа бид хоёрыг газраас анх ирж байна хэмээн хүндлэн оруулаад сайхан зантай хатан авхай, гүнж нар нь хүлээн авна. Тэндхийн хан хөвгүүд нь Дэгдүүлэй байвал яана? Тэр чинь тэнгэрийнхний тоонд орно шүү дээ гэхэд Бувардай өчигдөрхөн Дэгдүүлэйн ой дээр ямар хөгжилтэй байсныгаа санав. Нүдэнд нь самар, боов эрээлжлэн харагдаж хоосон ходоод нь хоржигноно. Уутханы ярианд бага багаар тайтгарч сэтгэл нь хөнгөрөөд нэг мэдэхэд нүд нь анилдан зүүрмэглэсэн байв. Түүний нойрон дунд Уутханы жингэнэсэн дуу тодорч,

-Бувардай бид нар шилтгээндээ хүрээд ирлээ. Энэ үүлнүүд ямар их нойтон чийгтэй байдаг юм бэ? гэх нь сонстох шиг болов. Унтаж байгаад гэнэт дааран сэрэхэд түүний хамаг биенд чийг татаж хамраас нь ус дусалж байлаа. Сайн сэрж амжаагүй нүдээ нээтэл хайрцагны ирмэг дээгүүр нэгэн бараан юм жирс хийн өнгөрөх шиг болов. Нойрмоглож байгаад нүдэнд юм харагдав уу, эсвэл элээ дайрч байгаа юм уу гэж бодоод айсандаа ухасхийн өндийвөл тэр хоёрын агаарын бөмбөлөг өндөр уулын бэлд ой модон дотуур нисч явлаа. Саяын нүдний буланд харагдсан бараан дүрс бол ногооноороо байгаа хушны орой байжээ.

Уутхан бас ядраад түүний хажууд унтаж байв. Эргэн тойрноо сайн ажвал хоёр талаараа модтой, дундаа бул чулуунуудын хоорондуур нэг ил гаран нэг далд орон шоржигнон урсах горхитой, горхины хоёр талын шарласан нуга дээр хэд хэдэн хөөрхөн жижиг зуслангийн байшинтай уулын ам байлаа. Намар болохоор айлууд хот уруугаа нүүгэд зуслангийн байшингууд эзгүй харагдана. Аажмаар уул улам өндөр болж Бувардайн суусан хийн бөмбөлөг ой дундуур зүсэн орлоо. Хажуугаар нь аажуухан өнгөрөх сүрлэг сайхан гацууруудын сиймхийгээр алсад харагдах үүл манан дотроос хотын байшингууд сүүмэлзэнэ. Модон дотор салхи үлээхээ больж, хийн бөмбөлгийн хурд саарч, аажмаар доошилсоор газар уруу ойртож байлаа. Гэтэл тэр хоёрын суусан бөмбөлөг навчаа гөвж нүцгэрсэн хус модны арзайж сэрийсэн мөчрийн дундуур орж тээглээд наашаа ч үгүй, цаашаа ч үгүй хоёр салаа мөчрийн хооронд зоогдлоо.

## ХОЁР НАЙЗ АВРАГДСАН НЬ

Бувардай эхлээд зоогдсоноо мэдсэнгүй. Буухад хэр ойр болж байгааг хэмжиж газар ширтэн дотроо баярлаж байтал нэг л биш ээ! Газар ойртох ч үгүй холдох ч үгүй нэлээд удав. "Салхи ийм бага байгаа юм байх даа" гэж бодон дээшээ харвал хийн бөмбөлөг хоёр мөчрийн хооронд тээглэн үүрэндээ тухлах шувуу шиг ажиг ч үгүй хэвтэнэ. Бувардай сая юу болсныг ойлгож мөчрийн хоорондуур хийн бөмбөлгөө гаргах санаатай үзэгний хайрцаг дотроо дэвхэцвэл тус болсонгүй. Харин бөмбөлөгтэй холбож уясан цаасан хайрцагны ирмэг сэтрэх байдалтай болсон харагдана. Тэгэхээр нь Бувардай дэвхцэхээ болив. Уутханыг сэрээх гэж яарсангүй. Яах аргаа олж ядан дээш доош харж бодол болон суув. Энд тэнд шувуу жиргэнэ. Хааяа чад хийн мөчир хугарах чимээ сонсогдоод нам гүм болно. Модны мөчрийн хоорондуур харагдах гүн цэнхэр тэнгэрт элээ эргэлдэнэ. "Тэр юугаа хийж тэнд эргэлдээд байгаа юм бол? Аягүй бол бидний хийн бөмбөлгийг харччаад учрыг нь олох санаатай эргэлдээд байгаа юм болов уу? Хэрэв тийм бол эртхэн Уутханыг сэрээж эндээс зайлах юм сан" гэж бодож байтал гэнэт,

-Ямар их шуугьдаг этгээд вэ? Унтуулахгүй юугаа хийж чихэн дээр шуухитнаад байгаа юм бэ? гэсэн нойрмог дуу сонстов. Бувардай эргэн тойрноо гайхан ажиглаж хэнийг унтахад нь саад болоод байгаагаа үзэх гэсэн боловч бүртгийх, бүртэлзэх юм даанч харагдсангүй. Гэтэл дахиад л,

- Хөөш чи, тэгэхээс тэгэх гэсэн шиг битгий харайлгаад байгаач! Хамаг амьтад унтчихаад байхад чинь чи энд пижигнээд байх юм. Нойр чинь хүрэхгүй бол холхон очиж шуухитна! Бид нар шөнөжин ан хийгээд ядраад байна. Одоо ялаа шумуул бүр ховордчихоод байгааг анхаарах хэрэгтэй гэж харанхуй хонгилын дотроос үглэх дуу дуулдав. Бувардай чимээ гаргахгүйг хичээж модны харанхуй хонгил уруу шагайвал тэнд ямар нэг үл танигдах амьтан дүүжлээстэй харагдав. «Бас бидэнтэй адил дүүжлэгдчихэж» гэж бодоод,

- Чи яачихсан юм бэ? Ингэж унтаж болдог юм уу? гэж Уутханыг сэрээчихгүйг хичээн амандаа шивнэхэд,

- Ерөөсөө унтуулахгүй нь гэж амандаа үглэх сонстоод,

- Унтахад битгий саад болооч гээд байхад чи хамаг тэнхээгээрээ

хашгичаад байх юм. Нойр хулжаачихлаа. Юу хийгээд наанаа тэлчлээд байгаа амьтан бэ гэж уурлан өгүүлэх сонстлоо.

- Би Бувардай байна. Бид сая нисч яваад хусны мечирт өлгөгдчихлөө. Газар буух гэсэн чинь чаддаггүй гэхэд,

- Газар бууж яах гэсэн юм бэ? Нэгэнт наанаа өлгөгдсөн бол наанаа унт. Шөнө болж сарьсан багваахайнууд босохоор хоёулаа уулзаж ярилцъя. Одоо нойр хүрээд байна. Ер нь энд өлгөгдсөн чинь чиний өөрийн буруу. Яах гэж өдөр ниссэн юм бэ? Тэгээд одоо хүн унтуулахгүй гэж зэмлэх дуулдав. Сарьсан багваахай гэж ямар амьтан байдгийг сонирхон хонгил уруу анхааралтай ширтэв. Бувардайн нүд харанхуйд дасч, хонгилд юу байгааг ялгаж эхлэв. Сайн ажиглавал нөгөө өлгөгдсөн бараан амьтан толгойгоороо урвуу харан дүүжлээстэй байлаа.

- Пөөх, та чинь яаж унтаж байгаа юм бэ? гэж өөрийн эрхгүй дуу алдчихав.

- Чи намайг бүр залхааж гүйцлээ. Яаж унтдаг юм бэ? Хөлөөрөө сайн дэгээдэж, доошоо хараад нүдээ тас аниад л унтахгүй юу! гэж тэсвэр нь алдагдаж байгаа бололтой нойрмоглон уцаарлахад Бувардай өөрийнхөө явдлыг зөвтгөн

- Үгүй, би ерөөсөө тэгж унтдаггүй. Би доошоо харж унтаж байгааг анх үзэж байна гэж тайлбарлалат,

- Минийхээр бол би дандаа доошоо харж унтдаг сарьсан багваахайнууд л үзсэн. Өөрөөр унтдаг багваахай ерөөсөө үзээгүй. Ойлгов уу?

- Ойлголоо.

- За тэгвэл цаашаа тонил гэв. Бувардай эхлээд гоморхсон боловч доошоо харж унтдагийг сонирхоод гоморхсоноо дорхноо мартав. "Нээрээ яагаад доошоо харж унтдаг юм бол? Сайхан зүүд толгойгоор нь дүүрдэг юм болов уу? Уутханыг сэрэхээр ярих юм байна. Дараа тэгж унтаж үзье" гэж дотроо шийдэв. Уутхан бөх гэгч нь унтсаар байв. Бувардайн өлөн гэдэс өөрийн эрхгүй хоржигнон дуугартал нөгөө амьтан өндөлзөн,

- Хөөш, чи одоо хүртэл шуугиад байна уу? Миний хамаг нойрыг хулжаачихлаа. Унтуулахгүй их марзганаад байвал би чамд үзүүлээд өгье гээд ууртай нь аргагүй хонгилоос гараад ирэв. Сарьсан хар далавчтай, далавчных нь үзүүрээс хурц хумс цухуйсан гялалзсан хар

биетэй амьтан харагдав. Бүлтгэр нүд, дэлдэн чих нь хусны мөчир дундаас хилэнтэй гялалзана. Оготно гэхэд далавчтай, шувуу гэхэд шүдтэй аймаар амьтан байв. Бувардай ухаангүй айж хайрцагны ёроолд нугдайн "Энэ амьтан том далавчтай савраараа хэзээ шүүрэн авах бол" хэмээн нүд анин хүлээв. Гэтэл нөгөөх нь хийн бөмбөлгийг Бувардай гэж андуурсан бололтой.

- Өө.. та байсан юм уу? Би тоглосон юм. Би нислээ нислээ гэсээр далавчаа хачин чимээгүй дэвэн бургасны хоорондуур нисч алга болов.

Орой тийш үүл арилж намрын шар нар уулын цаагуур жаргахаар дөхөж байлаа. Түүний өлгөгдсөн модны сүүдэр ойн цоорхойгоор нэг сунаж уртассан байв. Яахаа мэдэхгүй гайхаад сууж байтал дээр нь чимээ гарч тэр хоёрын суусан хайрцаг дээшээ доошоо савлан хөдлөв. Бувардай сандран дээш харвал хөөрхөн жирх тэр хоёрын байгаа мөчир дээр гарчихсан хийн бөмбөлгийг сонирхон үзэж байв. Бувардай түүнийг хараад санаа амрав. Хэрэв жирхний оронд түрүүний эргээд байсан элээ сууж байвал яана.

- Чамайг энэ хонгилд байсан сарьсан багваахай бидэн уруу явуулав уу? гэж Бувардай баярлан асуув. Нөгөө жирх тэднийг хийн бөмбөлгийн доор байгааг мэдээгүй байсан тул түүний дуунаас цочиж газар унах дөхөв. Арай гэж мөчир дээрээ тогтов. Тэр гурвын байгаа мөчир айхтар савлана. Уутхан ч тэдний дуугаар сэрэв. Тэр хоёрыг нөгөө жирх айхтар хянуур байдалтай ажиглаж,

- Үгүй ээ. Би түүнтэй сүүлийн хоёр сар дайралдсангүй. Тэр дандаа шөнө нисдэг юм гэж тайлбарлав. Уутханы нойр сэргэж,

- Бид газар буусан уу? гэж баяртай асуув. Бувардай толгой сэгсэрч

- Арай буугаагүй байна. Бид тээглэчхээд байна гэж түүнд хэлээд нөгөө жирхнээс,

- Чамайг тэгээд хэн явуулав? гэж асуухад,

- Хэн ч явуулаагүй. Хөөрхөн бөмбөлөг мөчирт өлгөөтэй байхаар нь хүрээд ирлээ гэж мөчрийн салаанд хөдөлгөөнгүй зоогдсон том улаан бөмбөлөг үрүү толгойгоороо дохив. Тэр жирх найган дайвалзаж байгаа мөчир дээр тоосон шинжгүй сууж байгааг Уутхан ажиглаж,

- Та яаж мөчир дээр гарч ирсэн бэ? гэж шагшин дуу алдахад нөгөө жирх нүдээ бүлтийлгэн, учрыг нь ойлгоогүй янзтай тонгойж өөрийн сууж байгаа мөчрийг тал талаас нь ажиглан мөрөө хавчаад,

- Авираад л гараад ирлээ гэж хариулав. Түүнийг модонд авирсан гэдгийг сонсоод Бувардай Уутхан хоёр ихэд сонирхон,

- Яаж авирдаг юм бэ? гэж зэрэг дуу алдав.

- Яахав дээ. Би жирх юм чинь амархан шүү дээ. Миний нэрийг Судландай гэдэг. Танилцъя! гээд гараа өгөв. Бувардай тэрэнтэй танилцахаар дуртай зөвшөөрч гараа сунгасан боловч хүрэхгүй байв. Судландай тэр хоёрын суусан хайрцгийг уяанаас нь татаж халуунаар гар атгалцав. Ингээд тэднийг нэгэнт мөчир өөд ойрхон татаж авчирсан тул Бувардай мөчир дээр дамжин гарах гэтэл Судландай гараа атгалцаж дуусмагц хайрцгийг тавьчхав. Уутхан Бувардай хоёр тэнцвэр алдаж хайрцагны мухар уруу шургачин унав. Сэхээрэн ажиглавал хайрцагнаас уясан утас хайрцагны ирмэгийг сэтлэх дөхсөн байлаа. Бувардай Уутхан хоёр болгоомжтой өндийж Судландай өөд харвал буруу юм хийсэндээ нэлээд гэмшсэн байдалтай тэднийг ажиглаж байв.

- Та хоёр гайгүй биз? Би мэдэлгүй тавьчихлаа гэхэд Уутхан түүнийг тайвшруулж,

- Зүгээр зүгээр, гайгүй. Харин саяныхаа барьж байсан утаснаасаа дахиад татахгүй юу гэж гуйлаа. Судландай:

- Яах гэсэн юм бэ? гэж асуулаа.

- Бид хоёр буух гэсэн юм. Чи туслахгүй юу? гэж гуйхад тэр дуртай зөвшөөрч,

- Тэгье тэгье. Би та хоёрыг буухад тусалъя. Модноос буух амархан шүү дээ гэж хэлээд утаснаас дахин дээш татав. Бувардай Уутхан хоёр мөчир дээр авиран гарлаа. Судландай тэр хоёрын урд хойно нь гарч нааш цааш сурмагаар дүүлэн мөчрийн уг хүртэл мөлхөхөд нь туслав. Тэр хоёр хэчнээн хүсэвч бие нь чичирч хүйтэн хөлс нь асгарч, ам нь хатаж, газар ахидаггүй. Судландай нэг чангааж, нэг нударч модонд



авирах элдэв арга барилын талаар ам хамхилгүй яриа дэлгэж, нарийхан мөчирнөөс тас зуурчхаад салахгүй байсан Бувардайг хүзүүн дээрээ суулган сурмаг гэгч нь газар бууж ирлээ. Буцаж гараад Уутханыг буулгахад Бувардай шиг төвөг удсангүй. Судландай тэднийг буулгах гэж багагүй хөдөлмөрлөж, багагүй хичээсэн тул модны ёроол дахь зөөлхөн хөвдөн дээр сандайлж бөөрөө түхэлзүүлэн амарч суув. Бувардай Уутхан хоёр ч дэргэд нь суув. Эргэн тойрон ой мод, навч цэцэг жигдэрч хажууханд нь шарласан навч, ойм хөвдөнд дарагдсан хожуул харагдана. Хар модны саарал ишнүүдийн нэг тал нь наранд гялбалзаж, нөгөө тал нь өтгөн сүүдэрт хучигдана. Наран талд байгаа уулын сүүдэр өөд харахад цэнхэр униар татаж түүний дэвсгэр дээр хааяа нэг ялаа эргэлдэж хаашаа нисэхээ мэдэхгүй цагааран гялалзаж харагдана. Тэртээ хол модны цаана нэгэн бяцхан бялзуухай үе үе дуу аялна.

Судландай газар хэвтээд, хар хар судалтай хус модны цагаан үйсэн дундаас бууж ирсэн замаа сонирхон ширтэж, бодлогоширч байснаа,

- Бид нар бөмбөлгөө модон дээр мартчихаж. Би одоохон аваад ирье гэж гэнэт босон харайлгаж мод өөд авирлаа. Тэр дээрээс,

- Та хоёр нисч чадахгүй, авирч чадахгүй мөртөө энэ хийн бөмбөлгийг яаж тэр дээр гаргасан юм бэ? гэж асууж байлаа. Тэр дорхноо хийн бөмбөлгийн дэргэд оччихсон мөчрөөс салгах гэж оролдож байгаа. Бувардай Уутхан хоёр дээшээгээ өлийн харж,

- Наадахыг чинь бид хоёр гаргаагүй юм. Харин бид хоёр дээр нь сууж, нисч ирсэн юм аа гэж ам амандаа дуугарахад Судландай гайхасхийн,

- Бөмбөлөг өөрөө нисдэг хэрэг үү? Далавчгүй мөртөө нисч байна гэж үү? Би шувууг далавчаараа л нисдэг гэж боддог байсан юм худлаа байх нь ээ! гэж ярих зуур хийн бөмбөлгийг салаа мөчрийн дундуур гаргах гэж хүчлэн чангааж байлаа. Бувардай түүнд хийн бөмбөлгийн нисдэг учрыг тайлбарлах санаатай амаа нээтэл нөгөө сайхан улаан бөмбөлөг хагарч жижигхэн улаан өөдөс болон унжлаа. Бөмбөлөг хагарахад гарсан дуу тэртээ ууланд цуурайтаж ой мод нэг хэсэгтээ чимээ аниргүй дуугаа хураав. Судландай цочсондоо аль хэдийн буучихсан дээшээ хараад зогсож байлаа. Тэр гурав түүрүүхэн хийн бөмбөлөг баясгалантай нь аргагүй бөмбөгөнөн байсан модны мөчрийг өрөвдсөн, гайхсан байдалтай ширтэн, саяхан байж байсан

зүйл нэг хормын дотор алга болчихсонд балмагдан, дуугарч чадахгүй баахан зогсов. Хамгийн түрүүн Бувардай сэхээ авч,

- Ха... хагарчихсан уу? гэж зэрэн дэмий л асуухад Судландай дээш харсан чигээрээ толгой дохиж юм хэлсэнгүй.

- Одоо бид хоёр яаж гэртээ харина аа? гэж Уутхан урамгүйхэн асуухад,

- Та хоёрын гэр хол уу? Явган яваад харьж болохгүй юу? гэж Судландай Бувардайгаас сандран асуулаа.

- Явган яваад энэ жилдээ багтаж хүрэхээргүй хол газар. Тэр хөндийд харагдаж байгаа хотод бид хоёр суудаг юм. Тийшээ хүрэхийн тул харанхуй ой, өргөн нуга, гүнзгий гол гатлах ёстой. Бид хоёр бөмбөлөггүй нисч чадахгүйгээс гадна усанд сэлж чадахгүй. Ганцхан бөмбөлөг л биднийг аврах байсан юм гэж гутрангүй тайлбарлав.

- Өө! Та хоёр тэгвэл юу ч хийж чаддаггүй юм байна шүү дээ? Одоо тэгвэл яана? гээд сэтгэл зовон бодолхийлж гүзээлзгэний улайж шарласан навчийг оролдож байснаа

- Энд дэмий зогсоцгоогоод яахав. Манайд очъё гэж санал гаргав. Уутхан Бувардай хоёр маш их өлсөж байсан тул нэрэлхэж цааргалсангүй. Судландайн урилгыг дуртай хүлээж авлаа. Судландай тэр хоёрыг өөрийн гэр байдаг горхины эрэг үрүү дагуулан явав.

- За одоо баруун тийш эргэцгээ. Шууд явах юм бол ёроолдоо устай нүх дайралдах учир зайлшгүй тойрох ёстой. Зүүн хөлөө энэ чулуун дээр тавиарай, тэгвэл баруун хөлөөрөө энэ үндэсний цаана гишгэдэг юм. Би үргэлж тэгж явдаг юм гэж тэр зам зааж өгч байв. Шарласан өндөр өвсний ёроолоор гаргасан жим даган тэд хурдлан алхав. Өвч дээгүүрээ шарласан боловч ёзоороороо ногоорч, шинэхэн ногоо соёолж харагдана. Сүүлийн хоногт энд дулаарсан юм байх даа. Эндхийн мод хашаанд байдаг модыг бодвол их өндөр, бүдүүн байх юм. Яагаад гэвэл өндөр уулан дээр ургадаг болоод тийм байдаг байх. Тэр хоёр Судландайг даган явсаар том том бул чулууны дундуур шоржигнон урсах горхины хөвөөнд ирэв.

- Та хоёр бул чулууны орой уруу хар даа гэж усны яг голд дүнхийн харагдах доогуураа усанд идэгдэж хөхөрсөн, дундуураа үерт долоолгон цайрсан дээрээ хожуултай, хожуулынх нь зарим хэсэг өвс ногоонд дарагдсан нөгөө хэсэг нь чулуунаас зэвүүцэх мэт сарвайж сэрийсэн үндэстэй аварга том бул чулууг заав. Хожуулын

өгөрч цайрсан үндсэн дотроос цорын ганц яндан гозойж харагдахыг сая олж харав.

- Харлаа, тэр байна. Лав дотроо дулаахан байх даа гэж дуу алдахад Судландай баяртай гэгч нь тосон авч,

- Тэгэлгүй яхав. Та хоёр ороод үзээрэй гээд горхины эргэн дээрээс сэгсийн унжсан өвсийг ярахад дотроо ус цэлэлзсэн том хөндий харагдав.

- Харж байна уу? гэж Судландай тэр хоёрын царайг өөрчлөгдөхийг анзааран баяртай хэлээд гозгор модноос уясан олсыг тайлан чангааж эхлэв. Устай хонгилын харанхуй мухраас нэг бараан юм дөхөж байгаа харагдана. Тэр хоёр юу гарч ирэхийг тэсэн ядан хүлээж янз янзаар тааварлаж байлаа. Судландай нэг их том загас барьж шарж өгөх гэж байгаа бололтой. Үгүй эсвэл газрын бөглөөг авч усыг нь гоожуулах гэж байгаа байх. Тэгээд гэртээ явган хүрдэг юм болов уу хэмээн элдвээр тааварлан зогсоцоотол нөгөөх бараан юм ойртсоор гэрэлд гарч ирлээ. Харсан чинь жижигхэн холтсон завь байлаа. Тэр хоёр амаа ангайлган алмайрахад Судландай,

- Завинд сууцгаа гэж урилаа. Тэр хоёрыг завинд суухад Судландай хүч заран сэлүүрдэв. Нуурын мандал дээгүүр алтан долгио гүйж, усны цаад эрэгт байгаа замагтай чулууг мөргөнө. Өндөр хөх чулууны хоорондуур цэвэрхэн тунгалаг ус цагаан хөөс цацруулан бургилан бууна. Горхины эргийг тойрон бамбай өвс, үхэр гоньд зэрэг өндөр өвс нягт хүрээлэн ханхалж, цаагуур нь ургасан мөнх ногоон гацуур, хушин мөчир тэнгэр халхлан тэднийг нөмөрч байв. Судландай сэлүүрдсээр гэртээ хүрч ирэв. Цагаанаар хөөсөрсөн ногоон замагны дунд нууцгайлан хийсэн шатанд тулахад тэд эрэг дээр буув.

Судландай гэртээ анхилуун үнэрт цэцэг навч дэвсчээ. Нүдэнд дулаахан тохилог сайхан хонгил байлаа. Тэр гурав цорын ганц яндангаараа пөг пөг утаа хаялуулан самар шарж идээд хот хөдөөгийг сониныг ярилцан нар жаргатал суулаа. Агаарын бөмбөлгөөр аймшиггүй зорчигч Уутхан Бувардай нар яаж ниссэн тухайгаа ярьж, сая усанд хөвөхөөс ямар ялгаатай болох тухай хүүрнэсээр гурвуулаа унтаж орхисон байлаа.

## ГЭРТЭЭ БУЦАХААР ШИЙДСЭН НЬ

Уутхан Бувардай хоёр Судландайнд олон хонолоо. Өдөр нь тэр гурав ой модонд явж, самар жимс цуглуулна. Уутхан эдгээр жимсээр элдэв янзын боов, амтат шүүс бэлдэнэ. Сүүлийн үед өдөр дулаахан байх боловч шөнөдөө их хүйтэрдэг болов. Ингэсээр байтал нэг мэдэхэд горхины ус хөлдөж өглөө босоход шоржигнох чимээ сонстохоо болилоо. Цас нэвсийн оров. Эргэн тойрон цав цагаан. Салхи хөдлөхөд саглагар ногоон хушны мөчир дээр тогтсон цас манаран унана. Өвөл тэртээ тэргүй самар, жимс, мөөг олдохоо байсан учир тэр гурав өдөржин гулгаж тоглодог байв. Харин зарим газар цас ухаж хонгил гаргавал нэг хоёр хөлдүү аньс олдоно.

Гулгаж тоглох их амархан. Шарласан навч олж мөсөн дээр тавьж суух юм бол газрын уруу нисэх мэт хурдална. Мөсөн дээр гулгах, ойгоор зугаалж цасаар шидэлцэн тоглох хөгжилтэй боловч төрсөн хашаа, найз нөхдөө санахад тэсч суумааргүй санагдана. Судландайн сонссоноор зарим хашир хэрэм, өвөөлж шувуу энэ горхийг хот ордог гэж батлан ярилцдаг гэнэ. Нөгөө талаас Судландайн хураасан хөрөнгө тийм ч чамлахааргүй харагдавч энэ чигээрээ эдний хоолноос хороон суух юм бол урин хавартай хэн хэн нь гэдэс цаггалан уулзаж чадахгүй нь ойлгомжтой болж байлаа.

Өвлийн нэгэн орой галын дэргэд сууж байхдаа Бувардай Уутхан хоёр Судландайд өөрсдийнхөө аяллын төлөвлөгөөг ярьж өгөв. Судландай эхлээд эрс эсэргүүцэж байв. Эцсийн эцэст тэр хоёрын ятгалганд автаж зөвшөөрлөө. Тэд явах бэлтгэлээ хийж, бургасны мөчрөөр чарга хийв. Нэгэн нарлаг өглөө Уутхан Бувардай хоёр гэртээ харихаар чаргандаа суув.

-Бид хоёр зун болохоор заавал эргэж ирнэ. Чамд хашаагаа үзүүлнэ гэв.

- Та хоёр манайд өвөлжөөд явбал аштай юу даа гэж Судландай гунигтай хэлэв. Уутхан Бувардай хоёр түүнийг хараад бараг замд гарахаасаа татгалзах дөхлөө. Гэвч тэр хоёр заавал явах хэрэгтэй байв. Ингээд газрын уруу хөдлөхөд,

- Найз нар минь замдаа сайн яваарай гэж Судландай хашгираад хойноос нь далласаар цасан дунд тормойтол хоцорлоо. Бувардай түүний сэтгэлийг сүүлийн удаа засах зорилгоор нүдээ нэг сайн

ирмэж аваад далласаар цасан хошуу тойрлоо. Чарга горхины мөс даган хурдалж явна. Тэр хоёр мөсний голд хөлдсөн чулуунуудыг чадмагаар тойрон хэвгий газрыг даган хотыг зүглэв. Зун боргио байсан мөсөн дээгүүр хүч аван харайлгаж хурдлан явтал өтгөн хушин ой шувтарч зуслангийн байшин гарч ирэв. Одоо эндээс хотын байшин харагдаж эхлэв. Гэтэл гэнэт горхины мөс өндөр дэнж дээрээс уруудаж, бөмбөлгөөр нисч явахад харагдаж байсан өргөн голын мөсөн дээр бууж орхив. Тэр хоёрын сууж явсан чарга хэдэн зүгтээ бутран Бувардай мөсөн дээр хаясан шагай шиг өнхөрч одлоо. Бувардай сэхээ автлаа нэлээд суув. Өмнө нь бүртийн харагдах зүйл бол өрөөсөн эсгий гутал нь бололтой. Уутхан хаашаа ч юм шидэгдэн алга болжээ. Доороос нь хүйтэн мөс хайрахад сая сэхээ авч тэнцэж ядан алхсаар гутлаа углаад Уутханыг эрж, ийш тийш саравчлан зогслоо. Хэн ч алга.

- Уутхан, Уутхан! гэж сандран хашгирч байтал гэнэт доороос нь,

- Би энд байна гэх дуу сонсогдлоо. Хөөс гүйж хөлдсөн нимгэн мөсний цаанаас Уутхан хашгирч байлаа. Бувардай мөсний ангал уруу үсрэн орж Уутханыг татаж гаргав. Тэр хоёр замынхаа хүнсийг мөсний ангалд орсон байхыг эрж олов. Удалгүй бүрэнхий болж цагаан гэгээ тасарсан учир зарим юм нь олдсонгүй орхив. Чарганы өрөөсөн ул харлан харагдах харзанд унаж мөсөн доогуур урсан алга болсон бололтой. Тэд голын нөгөө эрэг дээр гарав. Эргээс цааш хязгааргүй бургасан шугуй үргэлжилнэ. Тэр хоёр эцэж ядраад эргээс холгүй нэгэн саглагар бургасны доор орж хоноглохоор шийдэв. Өглөөгүүр Бувардай Уутхан хоёр сэрээд үүр цайж байгаа бүрхэг өдөр байгаа алин болохыг удтал ялгаж чадахгүй байв. Тэр хоёр хүүдийтэйгээ задалж дотроос нь Судландын бэлтгэж өгсөн самар, хатаасан жимсийг гаргаж ховдоглон идэв. Их ч өлссөн байлаа.

-Судландай яаж байгаа бол? Бид хоёрын төлөө санаа зовоод л сууж байгаа байх даа гэж Уутханыг хэлэхэд,

- Бид хоёрыг зун эргэж иртэл санаагаа зовоогоод л сууна байх даа. Яаж тэгж удаан санаагаа зовоож байх вэ, хоёулаа сайн явж байгаагаа яаж түүнд мэдэгдэх вэ? гэж ийш тийш ажигласнаа,

- Алив тэр унтаж байгаа шаазгайг цочоож сэрээе. Тэгвэл хоёр жижигхэн аюултай амьтан явж байна гээд хавиар нэг тараачихна. Судландай лав дуулж бид хоёрыг сайн явна гэж мэднэ хэмээн санал гаргав. Тэр хоёр сэмхэн гэтсээр ногооноор туяарсан урт сүүлтэй

шаазгай унтаж байгаа бургасны дэргэд ирэв. Тэр хоёр бургасны ишнээс барьж байгаад савлуулан хөдөлгөвөл нөгөө шаазгай цочсондоо муухай дуу тавин үргэж нислээ.

- За удахгүй бид хоёрын тухай бүх ойгоор ярих болно гэж Бувардай сэтгэл хангалуун хэлэв. Уутхан Бувардай хоёр идэх юмаа боож үүрээд ороолтоо чанга ороож малгайгаа духдуулан хотыг чиглэн замдаа гарлаа. Голын эргээр хөлдсөн хайрга чулуунд бүдчин хурдан явсандаа халууцаж, толгойноос нь уур савсаж байна. Тэдний цувралдан явахыг холоос харахад нэгэн жижигхэн галт тэрэг уухилан зүтгэх шиг үзэгдэнэ. Хоёр найз явсаар багагүй ядарч туйлдсан хойноо голын далан хүрчээ. Далангийн ёроолоос дээш харахад тэртээ дээр цантаж сааралтсан чулуу өлийж байв. Тэр хоёрыг жаахан эвгүй дуугарахад мөстсөн элс чулуу нурж үерийн ус шиг урсана. Тэд түр амсхийх зуураа далан дээр яаж гардаг билээ гэж бодоцгоов. Буцах замгүй тул авирахаас өөр аргагүй. Бувардай Уутханыг доороос нь дэмжин бээрсэн гараараа тулж зоримгоор авирч эхлэв. Чулуу хөл доороос мулт үсрэн, цас мөстэй холилдон өнхөрч, элс хайрга зогсолтгүй урсах нь авирахад саадтай.

Уутхан Бувардай хоёр бээрч сульдсан гараараа өвсний бүдүүн үндэснээс зуурч татан цувралдан мөлхсөөр нэг нэгийгээ хавиран салхинд сэржигнэх шарилжны хатсан шилбэ ёрдойсон далангийн орой дээр арай гэж гарав. Далангийн цаад талд хоёр хажуугаар нь мод суулгасан цардмал зам харлана. Зам дээр нэгээхэн ч хүн, машин харагдсангүй. Хоёр талаар нь нэвсийсэн цагаан цас даржээ. Цагаан цасны дундаас шивээ, хиагны толгой шаргалтан цухуйна. Мөн жижигхэн саравч замын хажууд байгааг олж харав. Энэ автобусны буудал гэдгийг Бувардай мэднэ. Түүний цаанаас модон дотор амралт сувиллын байшингийн шовгор орой цухуйна. Уутхан Бувардай хоёр шарласан өвсний шилбийг түшин хөлөө жийж амарч суух үед хоёр хөнгөн тэрэг хажуу бөөрөө гялалзуулан шүнгэнэж өнгөрөв. Зам дээр дахиад л эл хуль, зөвхөн салхи л цас хуйлруулан бүжиглэнэ. Хотын зүгээс улаан автобус ирээд явав. Автобусаас буусан хоёр эмгэн амралтын зүг гэлдэрч байна. Тэр хоёрыг амралтын хажуугийн гацуурын шугуйд ороход Бувардайн толгойд нэг шинэ санаа төрөв. Хэрвээ автобусанд яаж ийгээд сууж амжвал хотын төв хүртэл төвөггүй явж болох бөгөөд очсон хойноо гэрээ хэзээ ч олж болох билээ. Энэ үед

Уутхан нэлээд зайтай харагдаж байгаа хотын байшингуудыг ширтэж,

- Одоо цаашаа яаж явах вэ? гэж асуухад,

- Автобусаар явна гэж Бувардай шуудхан хариулав.

- Нээрээ тэгье! Ямар гоё вэ гэж Уутхан баярлан алга ташаад,

- За тэгвэл бушуухан буудал уруу очъё гэв. Тэр хоёр хамаг хүнсээ хувааж идээд дараачийн автобус ирэхээс өмнө амжихаар яарав. Хялганы бүдүүн шилбэнд өвдгөө цохин, цасан хунгарт зоогдон унасаар Уутханыг чирэн буудлын саравчинд оров. Тэнд Бувардай Уутхан хоёрыг гүйсээр ирэх хооронд хаанаас ч юм хоёр бяцхан охин дагуулсан өвгөн ирчихсэн автобус хүлээгээд зогсож байв. Автобус ирэх болоогүй л бололтой. Зам дээгүүр ган хоолой ачсан хүнд машин аахилан хүржигнэж өнгөрөв. Дахиад л нам гүм. Саравчинд зогсож байгаа охид шулганалдан өвгөн аавыгаа ноолж, хойно урдаас нь татан чангаана.

- Өвөө, өвөө! Та цасан хүн хийж чадах уу? Цөмөөрөө цасан хүн хийж аав ээждээ аваачиж өгье гэж том охиныг хүсэхэд бага нь баяртайгаар угтан авч,

- Өвөө, тэгье тэгье. Цасаар амьтан хийе. Туулай хийе. Манайд ерөөсөө амьтан байхгүй шүү дээ. Амралтаас гэртээ амьтантай очвол сонин шүү дээ гэж өвгөний ханцуйнаас татав. Өвгөн инээмсэглэж,

- Цасан амьтан гэрт хүрч чадахгүй хайлна. Цас гэдэг чинь хөлдсөн ус шүү дээ гэв.

- Би цасан туулайг наранд гаргахгүй хармаандаа эвтэйхэн аваад явна. Өвөө туулай хийе л дээ гэж зогсолтгүй гуйна. Өвгөн бас л,

- Халуун гэрт ороод л хайлчихна. Ус болоод урсана. Хэрэггүй гэж тэвчээртэй тайлбарлаж түүний духан дээр үнсэхэд жаал охин хэсэг бодсоноо,

- Тэгвэл загасны саванд аваачаад хийчихгүй юу! гоожиж алга болохгүй. Загаснуудтай хамт байна биз. Өвөө би цасан туулайтай болмоор байна гэж гуйсаар байв. Энэ үед автобус ирж зогсов. Нөгөө өвгөн хоёр ачаа дагуулан автобусанд оров. Бувардай Уутхан хоёр тэр өвгөний хоёр ачаа оруулах гэж уймарч тэвдэж байх хооронд өмдний шуумагны эргүүлсэн нугалааснаас амжиж зууран авахад автобусны тавцан дээр хамт гараад явчлав. Автобус дотор нэлээд хүнтэй байлаа. Сул суудал байгаагүй учир бусдыг дуурайн нэг хүний томдсон гутлын зуузайнаас барин зогслоо.

Өвлийн өдөр богиносч эрт харанхуй болно. Автобусан дотор чийдэн асав. Нэг удаа автобус зогсоход гаднаас ахимаг насны хар хүн ганган авгай дагуулан орж ирэв. Тэр хүн,

- Алив урагшлаарай. Та яагаад шахаад байна хэмээн дэргэдэх улсуудыг загнасаар чихцэлдэн урагшлав. Тэдний хажуугаар өнгөрч явахдаа нөгөө нь,

- Ёо ёо хөл дээр гишгэчихлээ гэж янгуучлав. Үнэхээр ч нэг зузаан ултай гутал хөл дээгүүр өнгөрөх нь өнгөрсөн юм. Нөгөө хүн тонгойж өөрийн хөлийг харах гэж байгаад тохитой нь аргагүй зогсож байсан Уутхан Бувардай хоёрыг үзчихэнгүүт,

- Оо... о! хэмээн муухай хашхирч цуг яваа хүнээс зүүгдэв. Нөгөө эр ч учрыг олоогүй боловч нүд нь том болж,

- Аа... а! гэж дуу тавив. Улсууд гайхаж,

- Юу болов, юу болов? гэж асууцгаахад нөгөө хүүхэн,

- Хулгана байна гэж хэлээд урагш зүтгэв.

- Өө юун сүртэй юм бэ? гэж нэг хүн хөхрөхөд зорчигчдыг цочсондоо ичсэн хоёр хүн урагш зүтгэсээр алга болов.

- Хулгана яагаад автобусанд ороод ирдэг билээ? Их сонин явдал байна гэж эрдэмтэн байрын хүн сонирхов.

- Муухай орилдог хүүхэн бэ? Цочсондоо зүрх амаар гарчих дөхлөө гэж нэг эмгэн тэднийг зэмлэж байлаа. Ингэж байтал өвөөтэйгөө автобусанд суусан жаал охин суудлаасаа босч Уутхан Бувардай хоёрыг чиглэн гэтэв.

- Хулганахан минь, хулганахан минь сандал доороо суугаарай гэж ам амандаа дуулцгаана. Тэд зун эрвээхий барьж байсныгаа санасан бололтой. Автобусан дотор байсан улсууд тэр охидыг нүд салгалгүй сонирхон ширтэж байлаа. Нөгөө хоёр хөөрхөн охид хөөрхөн атаахай олсондоо баярлаж уруулаа цорвойлгон нүүр лүүгээ унах үсээ хойш нь үлээсээр ойртов.

- Хөөрхий амьтад бүр даарчхаж. Бид өвөөд хэлээд та хоёрыг гэртээ аваачиж дулаацуулна гэж хоорондоо ярилцах ажээ.



- Битгий айцгаа. Бид хоёр та нарыг тэжээнэ. Тийм ээ, өвөө! Гэртээ аваачна тийм ээ? гэж хэлээд гараа явуулж эхлэв. Бувардай Уутхан хоёр айж цочсондоо хөдлөх ч сэхэлгүй шаланд хадуулчихсан юм шиг суусаар байв. Автобус хар хурдаараа хүржигнэн давхиж байхад хаашаа ч зугатах юм билээ. Хоёр охин Бувардай Уутхан хоёрыг нэг нэгээр нь тэвэрч,

- Эвий эвий хөөрхий амьтад. Өвөө! Бушуухан гэртээ харья. Эд нарыг дулаацуулъя гэгцээсээр суудал дээрээ буцаж ирцгээв. Тэнд байсан зарим улсууд

- Бариад авсан уу? гэж асуухад нэг хэсэг нь,

- Гаргаад хаячих, гаргаад хаячих гэж ятгаж байлаа. Эрдэмтэн гэмээр хүн,

- Сонин амьтад байна. Гаргаж хаяад яах нь вэ гэж тэднийг өмөөрөв. Гэтэл автобусны хойд талаас өөрийгөө ажил хэрэгч гэж их хүндэтгэдэг байрын хүн цонх онгойлгож тушаангуйгаар,

- Тэр хоёр жаал. Алив нааш аваад ир. Энэ цонхоор гаргаад хая гэж дуудав. Долигонуур зарим нь дорхноо түүнийг дэмжиж,

- Тийм тийм. Тэр хойд цонхоор хая. Тийшээ дөх. Энэ зайгаар хойшоо яв гэж тал талаас нь зөвлөж гарав. Нөгөө хоёр охин тэдний үгэнд орсонгүй, өвөөтэйгөө шивэглэлдэн ярилцаж Бувардай Уутхан хоёрыг өвөртөө тэврэн суусаар байв. Өвөө нь ч бас дээрэнгүй маягийн хүний шаардлагыг хүлээж авсангүй. Удалгүй тэд нар автобус зогсоход бууцгаалаа. Хоёр охин Бувардай Уутхан хоёрыг эвтэйхэн тэвэрч,

- Өвөө! Энэ хоёр амьтныг аваад явна, тийм ээ? гэж их л найдсан шинжтэй гуйцгаалаа. Өвөө нь зальтайхан инээмсэглэж,

- Танай цэцэрлэгийн багш нар амьтан ургамлыг хайрлаж хамгаалж бай гэж ярьдаггүй билүү? хэмээн асуухад,

- Ярьдаг, ярьдаг гэж хоёул шулганалдан хариулав.

- Тэгвэл наад амьтад чинь бас бидний хажууд байдаг цэцэрлэгт хашаанд байдаг амьтад шүү дээ. Тэднийг хайрлах хэрэгтэй. Та хоёрыг ч мөн нэгэн ижил барьж аваад амралтанд өвөөгүй нь үлдээчихсэн бол аав эзжийгээ санана биз дээ. Тэгвэл наад хоёрын чинь өвөө эмээ, аав ээж нь гэртээ хүлээж суугаа ч юм билүү, яаж мэдэх вэ. Миний хүүхдүүд наад амьтадаа хүний хөлөөс зайдуу тавьцгаачих гэж ятгав. Хоёр охин бодол болон зогссоноо санаа алдан өвөөгийнхөө үгэнд орж модны ёроолд овоолсон зөөлөн цасан дээр Уутхан Бувардай хоёрыг тавилаа. Тэгээд тэр гурав гэртээ харихаар эргэн эргэн харсаар яваад өгөв.

## НАЙЗ НАРЫНХАА ДУНД

Бувардай Уутхан хоёр айж сандраад хаана сууж байгаагаа ч анзаарсангүй. Лав л автобуснаас гарахад тал талд өндөр байшин сүндэрлэж, гудамжны чийдэн сүүн цагаан гэрлээ харамгүй цацаж, дэлгүүр хоршооны хаяг, хийн гэрэл янз янзын өнгөөр асч унтарч байлаа. Эрээлэн солигдох өнгө өнгийн гэрэлд олон хүн нааш цаашаа холхиж байгаа нь харагдаж, толгой дээгүүр модны мөчир сэрийж, хөнгөн тэрэгний гялгар бөөр, эмжээр төмөр гялтганаж, арын улаан гэрэлд улаан утаа савсаж байгаа нь нүдний буланд зэрвэс үзэгдэв.

Овоолсон цасан дээрээс бууж, бутны ёроолд орсон хойноо орчноо анзаарч харах чөлөө гарав. Тэр хоёр цасаа гүвж эргэн тойрныгоо сайн ажиглавал нэг л таньдаг оргиод байлаа. Автобусны буудал, талхны дэлгүүр, ягаан байшин яг мөн байна. Ийм аз гэж байх уу. Бувардай Уутхан хоёрыг өөрийнх нь гэрээс холгүй цасан хунгарт орхисон байлаа. Тэр хоёр баярлаж, улаалзганы бут даган гэрийн зүг алхлаа. Явган хүний замыг гаталж, зун багваахай цэцэг ярайж байдаг байсан Бувардайн хонгилын аман дээр ирэв. Тэндээс Уутханы хонгил уруу явлаа. Уутханы хонгил хашаан дотор байдаг билээ. Тэр хоёр одоо цасаар дүүрсэн элсний хашлагын дэргэдүүр өнгөрч хөглөгөр ногоон гацуурыг чиглэв. Хашааны энэ хэсэгт ургасан бут бургас яг л ууланд ургасан юм шиг шигүү учир тэнд явахад хашаандаа ирчихсэн гэж үнэмшихэд бэрх ажээ.

Уутханы хонгил уруу ойртох тутам хөхрөлдөх, дуулах чимээ ойртож байна. Бургасны араас болгоомжтой цухуйж харвал хонгилын өмнөх талбайд мөсөн гулгуур хийчихсэн дээр нь Дэгдүүлэй Түнтүүлэй, Жийвжийв бас хашааны хамгийн бүдүүн хөх бухандай Бүдүүнхэн нар гулган тоглож байв. Түнтүүлэй бас гоёсон хэвээр. Өнөөдөр сүүлэндээ тагтааны өд нэмж хатгасан харагдана. Түүнийг нааш цааш гулгахад хэн нэг нь гишгэж суга татах боловч байн байн авч сүүлэндээ хавчуулж харагдав. Тэд нар энэ жижигхэн мөсөн гулгуурыг тойрон байгаа долоогоно, үхрийн нүдний бутны мөчрийг өнгө өнгийн жижигхэн чийдэн, өнгөт зураг, хөөрхөн тоглоомоор чимжээ. Бувардай Уутхан хоёр тэднийг хараад л өнөөдөр шинэ жил болж байгааг тааварлав.

- Шинэ жилийн мэнд хүргэе! гэж Бувардай Уутхан хоёр тэдний

дунд гулган ороход эхлээд хэн ч таньсангүй, Тэд нар эхлээд,

- Шинэ жилийн мэнд! Шинэ жилийн мэнд! гэгцгээж байснаа нэг нь,

- Энэ чинь Уутхан байна шүү дээ гэж хашгирахад Түнтүүлэй жажуугаас нь,

- Энэ чинь Бувардай байна шүү дээ гэж баярлан тэвэрч авахад тэдний дунд ор сураггүй алга болсон оргодлууд ичингүйрэн зогсож байгааг таныцаажээ.

- Уутхан Бувардай гэж амьтан бүр ам амандаа хашгирч байлаа.


- За хонгилд орцгооё гэж Дэгдүүлэй урихад тэд цөмөөр Уутханыд орлоо. Найзууд нь Бувардай Уутхан хоёртой зэрэгцэж явах гээд нэг нэгийгээ нудралдан чихцэлдэцгээж, хөөрсөндөө учир тоймгүй янз янзын яриа урсгана. Уутханы хонгилд ороход тоос шороогүй цэвэрхэн байлаа.

Тэд хуучин оноо үдэж шинэ онтойгоо золгоцгооё гээд задгай гал асааж Түнтүүлэй Жийвжийв нар тал тал тийшээ амттан цуглуулахаар нисэцгээв. Тэд нар хамаг юмаа бэлтгээд баян тансаг

зассан ширээгээ тойроход гагцхүү Түнтүүлэй Бүдүүнхэн хоёр хамгийн их бялуу овоолсон тавагны дэргэд суух гэж өрсөлдөн хэсэгхэн зуур нудралцаад авав. Амьтан бүр хамгийн дуртай амттанаа сонгон, хамгийн дуртай ундаанаасаа авч ууна. Тавагтай бялууны дэргэд чихцэлдэн суусан Түнтүүлэй Бүдүүнхэн хоёрын сүүдэр задгай галын гэрэлд хоорондоо эвтэй нь аргагүй нийлэн хачин боольхон амьтныг хонгилын ханан дээр дүрсэлж байв.

- Та хоёр хаашаа алга болсон бэ? Түүнийхээ тухай яриач! гэж Дэгдүүлэй хэлэв. Бувардай Уутхан хоёр Заваандайн үгэнд орж хогийн машинд ачигдан хээр хаягдсан болоод үлийн цагаан оготнуудад баригдаж, амь алдах дөхсөн тухай болон агаарын бөмбөлгөөр ниссэн зэргээ их л сүртэй, нэг нэгийнхээ ярьсан зүйлийг тодотгон ам булаацалдан ярьсан нь Дэгдүүлэйн сэтгэлийг их хөдөлгөв. Түүний нүднээс нулимс дуслан гялтганаж, сэтгэлийн их хөдөлгөөндөө автагдаж найзыгаа чанга тэврэхээр үе үе ухасхийж байлаа.

- Бид та нарыг хаачсаныг ер мэдээгүй. Хүлээгээд л байсан, хүлээгээд л байсан. Ирэхгүй болохоор чинь хашааныхан цөм эрэлд гарсан. Та хоёрыг бид цөмөөрөө санаж, дэлхий дээр хамгийн сайн,



хамгийн ажилсаг амьтад байсан юм гэж ярилцдаг байлаа. Түнтүүлэй Бүдүүнхэн хоёр бүхнээс зүтгэлтэй эрэлцэж, нойр хоолноосоо гарах дөхсөн. Тэгээд тэр хоёр бидэнтэй найзлах болсон юм гэж Дэгдүүлэй хэлэв. Бувардай инээмсэглэж ингэж ярив.

- Танартих баярлалаа. Харин бид хоёр ой модонд очоод Судландай жирхтэй танилцсан. Тэр мөн их сайн жирх. Түүнийг зун ирэхээр нь та нартай найзлуулна. Судландай байгаагүй бол өдийд хөлдчихсэн байх ч юм уу яаж мэдэх вэ гэв. Бувардай цааш нь Судландай хэрхэн цуг байсан, ойд ямар байдаг тухай ярихад Уутхан хажуугаас нь яаж гэртээ буцаж ирсэн тухай нэмэрлэж, харин Дэгдүүлэй Жийвжийв нар тэр хоёрыг байхгүй байхад хашаанд ямар их уйтгартай байсан тухай ярьж байв. Ярианы төгсгөлд,

- Та хоёр жинхэнэ баатарлаг үйлс бүтээжээ. Тийм ээ? Түнтүүлэй гэж Дэгдүүлэй хэлэхэд Бувардай Уутхан хоёр жаахан ичингүйрч,

- Ямар баатарлаг үйлс тэр вэ? Бид хэнд тусалсан юм бэ? гэж даруухнаар эсэргүүцэв.

- Нэг нэгэндээ хамгийн хүнд цагт тусалсан шүү дээ. Тэр баатарлаг үйлс биш гэж үү? хэмээн ширээний ард сууж байсан бүх амьтад зэрэг шахам шагшин дуугарцгаалаа. Шинэ он гарч хуучин он халагдлаа. Тэд цөм баярлалдан аз жаргалыг хүсэн шуугилдаж байна. Ганцхан Дэгдүүлэй анд найз Бувардайгаа Судландайгаас жаахан харамлан гонсойсон боловч шинэ жилийн багт наадамд наадан эргэлдэн бүжиглэхдээ тэр тухай дорхноо мартаж дахин хөгжилтэй болов.

Удсангүй өвлийн өвгөн ч орж ирэв. Энэ жилийн өвлийн өвгөн маш хөөрхөн жижигхэн өвгөн байлаа. Тэднийг бэлгээ аваад гэр гэртээ тарж явахад ганц ч хүн унтаагүй, энд тэнд дуу хөгжим хангинаж баяр баясгалан дүүрэн бялхаж, айл бүрийн цонхонд өнгө өнгийн чийдэн асаалттай гацуур мод харагдана.

Харин бяцхан хүүхдүүд бөх гэгч нь тайван нойрсч, өглөөгүүр бэлэг авах тухай зүүдэлнэ. Бэлэг заавал очно. Ялангуяа Бувардай Уутхан хоёрыг аварсан бяцхан охин шиг тийм тусч сайхан сэтгэлтэй хүүхдүүдэд бэлэг заавал очно. Саяхан Уутханд орж ирсэн хөөрхөн өвлийн өвгөн манай хашааны бүх хүүхдэд хүрэхээр их бэлэг авч явна билээ.





Дэлхийн банктэй хамтран хэрэгжүүлж буй  
«Хөдөөгийн боловсролыг дэмжих  
(READ) төсөл»-ийн хүрээнд хэвлэв.  
Худалдахыг хориглоно.